## ЕРӨӨ СУМЫГ ХӨГЖҮҮЛЭХ 2024 ОНЫ ХӨГЖЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

2024 оны 12 сарын 16 өдөр Тавин

| № | Арга хэмжээ | Биелэлт | Биелэлтийн хувь |
|---|---|---|---|
| 1. НИЙГМИЙН БОДЛОГО | | | |
| Иргэдийн эрүүл энх, ая тухтай амьдрах, сурах, хөдөлмөрлөх боломжид суурилан нийгмийн баталгааг бий болгоно. | | | |
| 1.1 Эрүүл мэндийн бодлого | | | |
| Зорилт.Эрүүл мэндийн бодлогыг чанартай, хүртээмжтэй, үр дүнтэй хэрэгжүүлнэ. | | | |
| 1 | Ерөө сумын ЭМТөвийн барилгын ажлыг эхлүүлэх | Улсын төсвийн 1,7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Ерөө Эрүүл мэндийн барилга шинээр барих ажлыг "Нанобриллиант констракшн" ХХКомпани гүйцэтгэж ажлын явц 60%-ийн гүйцэтгэлтэй байна. | 100 |
| 2 | "Эрүүл хүүхэд Ерөөгийн ирээдүй" уриан дор хүүхэд багачуудыг урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан, эрүүл өсч бойжих нөхцөлийг бүрдүүлнэ. | 5 хүртэлх насны хүүхдүүдэд эрт илрүүлгийн урьдчилан сэргийлэх үзлэгийг 213 хүүхэд хийсэн хамруулсан. НҮБ-ын Хүүхдийн сан /Unicef/, Эх Хүүхдийн Эрүүл Мэндийн Үндэсний төв /ЭХЭМҮТ/, Сэлэнгэ аймгийн ЗДТГ, ЭМГ-аас хамтран зохион байгуулж буй " Хэрэхийн шалтгаант зүрхний өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах төслийн хүрээнд Т.Бямбаагийн нэрэмжит ЕБС-ийн 6-12 ангийн 374 сурагчдыг Стрептококийн халдвар илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулсан<br>2024 оноос эхлэн заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу 11 настай охид, хөвгүүдийг хүний папиллома вирусийн халдварын эсрэг вакцинийг Т.Бямбаагийн нэрэмжит ЕБС-ийн 11 настай 65 хүүхдэд вакцинжуулалт хийлээ. Хамралт 75.5<br>Дотуур байрны 71 хүүхдэд цагаан хорхойн шинжилгээ хийж, ариун цэвэр эрүүл ахуйн зөвлөгөө өгч, эерэг гарсан 6 хүүхдэд цагаан хорхойн эм өгсөн Нарлаг цэцэрлэгийн 213 хүүхдэд, амны хөндийн үзлэг хийж, шүдний эмчийн үзлэгт 56 хүүхэд хамрагдсан бөгөөд 530 хүүхэд давхардсан тоогоор цусны ерөнхий шинжилгээ, цагаан хорхойн шинжилгээ өгч эерэг гарсан 16 хүүхдийг эмчлэн эрүүлжүүллээ.<br>Сургууль, цэцэрлэгийн хүүхдүүдэд намар хаврын улиралд жилд 2 удаа нийт 564 хүүхдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж зөвлөгөө, сургалт мэдээлэл өгдөг. Үзлэгээр хүүхдийн өсөлт хөгжил, амны хөндийн эрүүл ахуйн үзлэг зөвлөгөө хийдэг. Энэ оны үзлэгийг өмнөх оны үзлэгтэй харьцуулахад амны хөндийн өвчлөл буурсан байна. | 100 |
| 3 | Хөдөөгийн өрх, малчдад жилд 2-оос доошгүй удаа эрүүл мэндийн үйлчилгээг | ЭМТөвөөс нийт 2 удаа малчин өрхүүдээр явж үзлэг оношилгоо хийж эрүүл мэндийн тусламж үйлчилгээг 54 өрхийн 164 иргэнийг үзлэгт хамруулж өндөр настан 20 хүн, Хөгжлийн бэрхшээлтэй-6, 0-5 настай хүүхдийн үзлэг -26, Дархлаажуулалтад – 65, -Хачигны вакцин 1-р тун- 12 ,2-р тун- 10 , 3-р тун- 15 хүнийг хамруулж эрүүл | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | хүргэж ажиллана. | мэндийн зөвлөмж бүхий брошюр нийт 48 ширхгийг тараасан | |
| 4 | Эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг төлөвшүүлэх иргэдрүү чиглэсэн эрүүл мэндийн сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлж, халдварт болон халдварт бус өвчлөлийг бууруулна. | Хүн амыг халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 5 удаагийн сургалт , 8 төрлийн ажил арга хэмжээг, 10 удаагийн үзлэг оношлогоо хийх зэрэгт нийт 2250 гаруй хүнд үзлэг оношлогоо,сургалт сурталчилгаа нөлөөллийн ажил хийсэн байна | 100 |
| 5 | Иргэн бүрийг жилд 1 удаа урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх нарийн мэргэжлийн эмчийн үзлэг оношлогоонд хамруулна. | Хүн амын зорилтот бүлгийн иргэдэд урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үзлэг хийж, артерийн даралт, чихрийн шижингийн эрт илрүүлэгт 2100 хүн хамруулж 100 хувийн үзүүлэлттэй байна.Элэгний эрт илрүүлэгт 845 хүн буюу хамрагдвал зохих иргэдийн 46.8 хувийг хамруулсан бөгөөд элэгний В вирустэй-9, С вирустэй 11 хүн илэрч хяналтанд авсан.<br>Хөх, умайн хүзүүний хорт хавдар илрүүлэх урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийн 60 хувийг хамруулсан бөгөөд шинжилгээнд өөрчлөлттэй гарсан 4 хүнийг давтан шинжилгээнд хамруулж хяналтанд авч ажиллаж байна .<br>Халдварт өвчин бэлгийн замын өвчлөл -0 , сүрьеэ -2 хяналтад байна, Коронавирусийн халдвар 2 тохиолдол бүртгэгдсэн.<br>ЭМГ, СНЭ-ийн дэмжлэгтэйгээр Ерөө сумын 202 иргэнд хиймэл оюун ухааны технологийг ашиглан уушгины болоод сүрьеэ илрүүлэх үзлэг оношлогоог хийлээ. Үзлэгийн дүнд 46 хүн эмгэг өөрчлөлттэй гарснаас сүрьеэгийн хяналтанд эмчлэгдсэн-16, уушгины нарийн мэргэжлийн байнгын хяналтанд байгаа-2, дээд шатлалын эмнэлэгт , онош тодруулах шаардлагатай /КТГ хийлгэх/-2, цэрний шинжилгээ өгөх шаардлагатай-7 хүн илэрсэн байна.<br>Урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт 392 хүн хамрагдсанаас тэмбүү 15 буюу 3,8 хувьд илэрснийг эмчлэн эрүүлжүүлсэн. | 100 |
| 6 | Ерөө ЭМТөвд тусгай хэрэгцээт иргэн, хүүхэд багачуудыг эмчлэх өрөөг тохижуулж ээлтэй орчинг бүрдүүлэх | • Үйлчлүүлэгчийн Хөтөч хүлээн авах хэсгийг тохижуулж хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан налуу шат, тэргэнцрийг үүдний хэсэгт байрлуулсан.<br>• Эрүүл мэндийн төвийн хэвтэх эмчлүүлэх хэсэгт цэвэр, бохир усны системд холбогдсон ариун цэврийн өрөөтэй болсон бөгөөд жорлонгийн суултуур, био 00, угаалтуур нь эвдрэл гэмтэлгүй, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, жирэмсэн эмэгтэйчүүд, өндөр настай хүмүүст ээлтэй орчин бүрдүүлэхэд анхаарч тохижуулж, тухтай орчин бүрдүүлсэн.<br>• Хөгжлийн бэрхшээлтэй иргэд үйлчлүүлэх налуу шат болон шатны бариулыг хийж хөгжлийн бэрхшээлтэй иргэд саадгүй үйлчлүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.<br>• Харааны бэрхшээлтэй болон өндөр настан, унах эрсдэл өндөртэй хүмүүст зориулсан ханын бариултай.<br>• Өрөө тасалгаанууд босгогүй. Тулгуур хөдөлгөөний бэрхшээлтэй болон хэвтрийн хүнд өвчтэй иргэдэд зориулсан тэргэнцрийг үүдний хэсэгт байрлуулсан. | 100 |

<table>
<tr><td></td><td></td><td><ul><li>Гадна орчны болон  дотор гэрэлтүүлэг сайтай.</li><li>Хэвтэн эмчлүүлэх хэсэгт хөгжлийн бэрхшээлтэй болон тусгай хэрэгцээт өвчтөн хэвтүүлэн эмчлүүлэх хэсэг гаргасан.</li><li>ЭМТ-ийн гадна автомашины зогсоол шинээр хийгдсэнтэй холбоотойгоор явган замын өөрсдийн нөөц бололцоогоор хийв.</li></ul></td><td></td></tr>
<tr><td>7</td><td>Бугант ЭМТөвийг төрөх ор, эхо аппаратаар хангах</td><td>Эх барих эмэгтэйчүүдийн ахлах зэргийн эмч, Анагаах ухааны доктор, Ерөө нутгийн охин Хонгор овогтой Энхдэлгэр эмч маань гэр бүлийн зүгээс 6.5 сая төгрөгийн үнэ бүхий бүрэн автомат эмэгтэйчүүдийн үзлэгийн ор хандивлалаа</td><td>100</td></tr>
<tr><td>8</td><td>Сумын иргэдэд эрүүл зөв хооллолт, стрессээ удирдах, хөдөлгөөний хомсдлоос сэргийлэх, бие бялдраа хөгжүүлэх дасгал, иог, бүжиг хийх зэрэг үйлчилгээг авах бололцоо бүхий “Эрүүл зөв амьдрал төв”-ийг ажиллуулах бололцоог улсын төсөв, хувийн хэвшлийн оролцоотойгоор дэмжин хөгжүүлнэ.</td><td>Нийт ажилчдын эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх, эрүүл зөв хооллолт, дасгал хөдөлгөөнийг дэмжих замаар хамт олны эрүүл мэндийг бэхжүүлэх, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Түмэн дасгалыг ажлын байрандаа хийж хэвшүүлж , Ажлын байрны дасгал хөдөлгөөн челлензид оролцож #Дээрэлхэл_Дэлгэрэх_Ёсгүй аянд нэгдсэн</td><td>100</td></tr>
<tr><td colspan="4">1.2 Боловсролын бодлого</td></tr>
<tr><td colspan="4">Хүүхэд багачууд, иргэдэд хүртээмжтэй, чанартай, хэрэгцээнд нь нийцсэн боловсрол эзэмших тэгш боломжийг бүрдүүлнэ.</td></tr>
<tr><td>9</td><td>“Чадварлаг багш” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажиллана.</td><td>ЕБСургуулийн 2023-2024 оны хичээлийн жилд ”Багш, сурагч солилцоо” хөтөлбөрийн хүрээнд  хими, физикийн  багш, захирал, сэтгэлзүйч нар Япон улсад, англи хэлний 1 багш БШУЯ-ны Ази-Номхон далайн орнуудын “Багш солилцоо” хөтөлбөрт хамрагдан Солонгос улсад 3 сар тус тус мэргэжлээ дээшлүүлэн хуримтлуулсан мэдлэг, мэдээллээ багш нартаа түгээн ажиллаж байна. СӨБоловсролын 25 багш, удирдах ажилтнууд 10 удаагийн цахим сургалтанд хамрагдаж 5 удаа нээлттэй үйл ажиллагаа зохион байгуулж бусдадаа туршлагаа түгээн ажиллаж байна. Мөн  БЕГазраас зохион байгуулсан 1-ээс дээш жил ажиллаж байгаа 5 багш үндсэн сургалтанд, “Багшийн модуль” сургалтанд 13 багш, удирдах ажилчид хамрагдсан байна. “Чадварлаг багш” хөтөлбөрийн хүрээнд СӨБоловсролын хамран сургалт, ЕБСургуулийн хамран сургалт байж багшийн заах арга, сурган хүмүүжүүлэх байдал ахиж хүүхэд багачууд тав тухтай орчинд сурч боловсорч байна. ЕБС: 2024-2025 оны хичээлийн жилд “ Чадварлаг багш” арга хэмжээний хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулан ажиллалаа.Үүнд:<br>1.Багшийн мэргэжлийн  тасралтгүй хөгжлийг  дэмжих сургалт:Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих нийт 56 төрлийн сургалтад нийт давхардсан тоогоор 805 багш хамрагдсан байна.Үүнд:<ul><li>Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад нийт 6 багш, 1 удирдах ажилтан хамрагдсан ба Эхний жилийн үндсэн сургалтад – 3 багш, 1 удирдлага 5 дах жилийн үндсэн сургалтад – 2 багш 10 дах жилийн үндсэн сургалтад – 1 багш</li></ul></td><td>100</td></tr>
</table>

| | | | |
|---|---|---|---|
| | | • Багшийн мэргэшлийн хөгжлийг дэмжих сургалтад нийт 55 багш хамрагдсанаас Зорилтот сургалтад 27 багш, Сонголтод сургалтад нийт 28 багш хамрагдаж багш нарын сургалтын төлбөрийг багшийн хөгжлийн зардлаас шийдвэрлэж нийт 3100000 төгрөгийг зарцуулсан байна.<br>• Багшийн хөгжлийн дэмжих орон нутгийн хэмжээнд зохион байгуулсан цахим болон танхимын 15 төрлийн сургалтад 48 багш<br>• Ажлын байран дээр 37 төрлийн сургалтад нийт давхардсан тоогоор 678 багш тус тус хамрагдаж мэргэжил, ур чадвар, арга зүйгээ дээшлүүлэн ажилласан байна.<br>• “ Явцын үнэлгээний арга зүй “ -н сургалтад 17 багш цахимаар хамрагдаж арга зүйгээ дээшлүүлсэн байна.<br>2.Багшийн хөгжлийг дэмжих бусад үйл ажиллагаа.Багшийн хөгжлийг дэмжих зорилгоор нийт 11 төрлийн үйл ажиллагаа зохион байгуулж эдгээр үйл ажиллагаанд давхардсан тоогоор нийт 159 багш оролцсон байна.Үүнд:<br>• “Зочинтой хичээл ” – үйл ажиллагааг нийт 26 багш зохион байгуулсан байна.<br>• “Хамтын оролцоонд суурилсан сургалтын байгууллагын менежментийг хөгжүүлэх нь “ сэдэвт сурган хүмүүжүүлэх илтгэлийн уралдаанд нийт 27 оролцсон байна.<br>• Ерөө бүсийн багш нарын Илтгэлийн уралдааныг зохион байгуулж бүсийн нийт 20 багш оролцсон байна.<br>• “ Сайн хичээл – үйл ажиллагаа “ зохион байгуулж нийт 8 багш оролцлоо.<br>• Мэргэжлийн хичээлийн төрөлжсөн олимпиадад 11 багш амжилттай оролцлоо.<br>• Элсэлтийн шалгалтад бэлтгэх үйл ажиллагаанд мэргэжлийн 9 хичээлээр нийт 98 сурагчдыг бэлтгэн ажилттай оролцуулж нийт 7 сурагч 600 дээш оноо авсан байна.<br>• “ Эх хэл – Бидний соёл “ нэрэмжит олимпиадыг амжилттай зохион байгуулж анги удирдсан 21 багш сурагчдаа амжилттай бэлтгэн оролцуулсан байна.<br>• 1-5 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарын дунд “ Ур чадвар” -ын уралдаан зохион байгуулж 9 багш оролцож өөрсдийн заах арга зүй, ур чадвараа харуулан өрсөлдлөө.<br>• 5-аас дээш жил ажилласан багш нарын дунд “ Надад нийт туршлага бий “ уралдааныг зохион байгуулж нийт 10 багш оролцож өөрсдийн хуримтлуулсан туршлагаа хэвлэмэл байдлаар хийж бусад багш нартаа түгээн ажиллалаа.<br>• “ Сэлэнгэ аймгийн залуу багш нарын манлайлал “ арга хэмжээнд 1-10 жил ажиллаж байгаа залуу 17 багш оролцож аймгийн хэмжээнд өөрсдийн ур чадвар сорин оролцлоо.<br>Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг өнгөрсөн жилээс 1.69% -р ахиулан 4-р түвшний үнэлгээгээ бататгалаа. | |

| | | | |
|---|---|---|---|
| | | Багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд нийт 26 багш хамрагдаж 65% буюу нийт үнэлэгдсэн багш нараас 17 багш нь 2-4-р түвшинд үнэлэгдэж 15%-40% урамшуулал авч байна.<br>Сургуулийн захиргаа амжилт үзүүлэн бусдыгаа манлайлан амжилт үзүүлсэн дээрх 23 багшийг сургуулийн дотоод журамд заасны дагуу үндсэн цалингийн тодорхой хувиар урамшуулан дэмжин ажиллаж байна.<br>СӨБ: Чадварлаг багш хөтөлбөрийн хүрээнд эрхлэгч, арга зүйч, бүлгийн 8 багш, хөгжмийн багш Багшийн мэргэжил дээшлүүлэх инстутээс зохион байгуулдаг модуль сургалтад хамрагдаж батламжаа авсан. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд боловсруулсан зөвлөмж” сургалтад эрхлэгч арга зүйч, 8 багш хамрагдсан. Ялгаатай хэрэгцээтэй хүүхэдтэй ажиллах арга зүй сургалтад 9 багш арга зүйч хамрагдсан.Багш нар байгууллага дээрээ 2 бүлэгт хуваагдан мэргэжлийн хөгжлийн бүлэг байгуулан үйл ажиллагааны төлөвлөгөөгөө гарган ажиллаж байна. Мөн багш нар аймгийн багш нарын мэргэжлийн хөгжлийн 5 бүлэгт өөрийн сонголтоор орж ажиллаж байна.<br>2023-2024 оны хичээлийн жилд багш нар аймгийн мэргэжлийн багш нарын бүлэгт хуваагдан хуваарилагдаж мэдлэг боловсролоо дээшлүүлэн хамтран ажиллаж байна. Эрхлэгч П.Баярцэнгэл нь Сэлэнгэ аймгийн мэргэжлийн багш нарын бүлгийн ХЭМ ийн бүлгийн ахлагчаар ажиллаж байгаа бөгөөд бүлгийн гишүүдийн уулзалтыг 1 удаа , Бүлгийн удирдлагын багийн уулзалтыг 1 удаа зохион байгуулж бусдадаа мэдээ мэдээллийг өгч чиглүүлэн удирдан ажиллаж байна. | |
| 10 | Бугант тосгонд 640 хүүхдийн шинэ сургууль барих ажлын зураг төсвийг хийлгэх, барилга байгууламж барих асуудлыг холбогдох шатанд уламжилсан байна. | 2025 оноос эхлэн шинээр баригдах 640 хүүхдийн ЕБС-ийн зураг төсвийг Онч тэнхлэг ХХК-р хийж гүйцэтгүүлж байна.Онцгой байдлын ерөнхий газар, Эрүүл мэндийн газруудад холбогдох материалыг хүргүүлэн үнэлгээг хийлгэж байна. | |
| 11 | Ерөө сумын ЕБСургуулийн 150 хүүхдийн дотуур байрны зураг, төсвийг хийлгэх | Дотуур байрны асуудлыг холбогдох шатанд уламжилж шийдвэрлүүлсэн байна. | 100 |
| 13 | Сумын төвөөс алслагдсан өрхүүдийн хүүхдүүдийг зөөвөрлөх “Сургуулийн автобус”-ыг ажиллуулж хүүхдүүд сургуульдаа аюулгүй ирж, буцах нөхцөлийг бүрдүүлнэ. | Шаардлагатай унаа, тээврийн хэрэгслээр ханган сумын төвөөс 7 км хол амьдардаг сургуулийн болон СӨБ-ын хүүхдүүдийг сүүлийн 4 жил зөөн ажиллаж байгаа.<br>Тус сумын 1-р багийн иргэн Жигмэддоржийн Оюунтөгстэй 2024.09.27-ны өдөр “Ажил гүйцэтгэх гэрээ” байгуулан 2024.09.18-2024.12.31-ний өдөр хүртэл Буурагчин 2-р баг Гэрэлтхайлааст хэсэгт оршин суудаг сургуулийн сурагчдыг өглөө, орой зөөх ажлын гэрээ байгуулан өдөрт 20лт шатахуун, сарын ажлын хөлсөнд 660,000 төгрөгийг тус тус олгож байна. | 100 |
| 14 | Хүүхэд багачуудын хөгжих боломжийг бүрдүүлэх зорилгоор “Спорт тоглоомын талбай”, “Дугуйн талбай”-г шинээр байгуулж | Ерөө сумын хүүхэд багачуудын хөгжих боломжийг бүрдүүлэн “Спорт тоглоомын талбай”, “Дугуйн талбай”-г шинээр байгуулсан.“ Сумын хэмжээнд дугуй унах хүүхдүүдийн тоо нэмэгдсэн. | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | “Дугуйтай Ерөө” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | | |
| 15 | Багш, суралцагчийн хөгжлийг дэмжиж элсэлтийн ерөнхий шалгалтад өндөр оноо авсан сурагч, бэлтгэсэн багш, улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэн мэргэжлийн хичээлийн багшийг урамшуулж тэтгэлэг олгохын зэрэгцээ өмнөх жилийн ЭЕШалгалтын түвшинг ахиулахад анхаарч ажиллана. | 12-р ангийн 33 сурагч 10 хичээлээр давхардсан тоогоор 103 сурагч цахимаар хамтран ажиллах гэрээг байгуулан ажилласны үр дүнд 4 хичээл улсын дунджаас дээгүүр үнэлэгдсэнээс гадна Орос хэлний хичээлээр аймагтаа 1-рт, Түүхийн хичээлээр 3-рт эрэмбэлэгдсэн амжилтыг үзүүлсэн. Багшид сургуулийн зүгээс ур чадварын нэмэгдэл олгосон. | 100 |
| 16 | Жилдээ орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцаж буй 10-аас дээш оюутны сургалтын төлбөрт зохих дэмжлэгийг үзүүлж их, дээд сургууль төгсөөд орон нутагтаа ажиллах гэрээг байгуулан хамтарч ажиллана. | Орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр суралцах оюутны сургалтын төлбөрийг БТЕГ ХХК-ны Баян сангаас нийт 25 оюутны 45.0 сая төгрөгний сургалтын төлбөрийг төлж дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж байна. | 100 |
| 17 | Төгсөх ангийн сурагчдын дунд “Мэргэжил сонголт” арга хэмжээг уламжлал болгон зохион байгуулж, мэргэжлээ сонгоход нь арга зүйн зөвлөгөө, зөвлөмжийг өгч, ажлын байртай танилцах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлнэ. | Насан туршийн сургалтын ажил мэргэжлийн чиг баримжаа олгох хөтөлбөрийн хүрээнд 6-11-р ангийн нийт 334 сурагчдад “Зорилгоо тодорхойлохын ач холбогдол “сэдвээр сургалт явуулж “ Мэргэжлээ та сонгож чадсан уу” судалгаа авахад нийт 44 сурагч сонгоогүй байсан бөгөөд эдгээр сурагчдын анги удирдсан багш, эцэг эхчүүдэд мэргэжил сонголтын чиглэлээр зөвлөгөө өгсөн.<br>Дархан-Уул аймгийн ШУТИС, МСҮТ, Мандах, Зохиомж, Сэлэнгэ аймгийн Политехникийн коллеж, сургуулиудаас багш нар ирж их дээд сургуулийн танилцуулга, мэргэжил сонголтын талаар 10-12-р ангийн давхардсан тоогоор 142 сурагчдад мэдээлэл өглөө. ОХУ-ын сургуулиудын мэдээллийг 12-р ангийн 33 сурагчдад цахимаар өгсөн. Ерөө сумын ИТХ-аас санхүүжүүлэн “мэргэжил сонголт”-ын чиглэлээр 8-11-р ангийн 236 сурагчдад 1 өдрийн сургалтыг зохион байгуулсан.Сургуулийн зүгээс төгсөх ангийн сурагчид, эцэг эхчүүдэд мэргэжил сонголт, их дээд сургуулиудын танилцуулга,оюутны тэтгэлэгийн талаар хамтын уулзалтыг зохион байгуулсан бөгөөд төгсөх ангийн 103 сурагч, 52 эцэг эх, мэргэжлийн 12 багш оролцсон. | 100 |
| 18 | Сум, тосгонд нэн шаардлагатай байгаа мэргэжлийн багшийн нийгмийн асуудлыг шийдвэрлэж тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлж ажиллана. | Бага ангид шинээр төгсөж ирсэн 2 багшийн орон байрны асуудлыг шийдсэн ба туршлагатай багшид даалган өгч залгамж холбоотойгоор багшлах ажилд нь зөвлөн туслуулж байна. | 100 |
| 19 | Ерөө шинэ сургуулийн хайрган суурьтай авто зогсоолыг асфальтаар хучина. | “Жинчингранд” ХХК 695.0 сая төгрөгөөр ЕБС-ийн 2100 м$^2$ талбайтай хайрган хучилттай авто зогсоолыг асфалтьтаар хучих хийсэн. /4 замын уулзвараас колонк хүртэлх 1.02 км% 1.2 км дугуйн зам хамт хийсэн./ | 100 |
| | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих тусгай танхим байгуулах | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг дэмжих зорилгоор “Тусгай танхим” байгуулах төслийг сумын ИТХ-д оруулсан боловч дэмжигдээгүй. Сургуулийн хэмжээнд оношлогдсон хөгжлийн бэрхшээлтэй 13 суралцагч байна. Үүнээс сонсголын бэрхшээлтэй 1, оюун ухааны бэрхшээлтэй 5, өвчний оноштой 7, хавсарсан оноштой 1 суралцагч, байнгын асаргаа шаардлагатай 12 суралцагч | |

| | | | |
|---|---|---|---|
| 20 | | байна. 11 суралцагч танхимаар, 2 суралцагч зайнаас суралцаж байна. 7 суралцагч дугуйланд хамрагдан хөгжиж байгаа бөгөөд 2 сурагч “Эсгий урлал наамал” төрлөөр бүтээлийн үзэсгэлэнгээ гаргаж Ерөө бүсийн хүүхдийн урлагийн наадамд эсгий урлалын бүтээлээр оролцож алтан медаль хүртсэн амжилтыг үзүүлэн хөгжиж байна. Урлагийн наадмын 2-3 төрөлд 9 сурагч хамрагдан оролцсон. “ Тэгш хөгжье” уриатай өдөрлөгийн хүрээнд ХБ-тэй 15 хүүхэд, 15 эцэг эхийг Дархан-Уул аймгийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төв”-ийн үйл ажиллагаатай танилцуулах, мэдээлэл өгөх, ерөнхий эмчийн үзлэг, нөхөн сэргээх үйлчилгээнд хамруулсан. | |
| 21 | Ерөө сумын цэцэрлэгийн “Багш хөгжлийн төв”-д шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах | Багш нарын сургалтын хэрэгцээнд 41.497.000 төгрөгний өртөг бүхий тоног төхөөрөмж сургалтын хэрэглэгдэхүүнээр хангагдлаа. Үүнд зөөврийн компьютерүүд, ухаалаг дэлгэц, багш нарын хурлын ширээ сандал, зурагтаар хангагдлаа. | 100 |
| 1.3 Соёл, урлагийн бодлого | | | |
| Зорилт. Байгалийн унаган төрхийг хамгаалж уламжлалт ёс заншил, соёлын өвийг түгээн дэлгэрүүлэн монгол хүний бүтээлч сэтгэлгээ, ур чадвар, авьяас билгийг хөгжүүлж, нийгмийг соён гэгээрүүлнэ. | | | |
| 22 | Сумандаа 400 хүний суудалтай шинэ соёлын төв барих ажлыг эхлүүлэх | Сумын Засаг даргын мөрийн хөтөлбөрийн 3.1-д заасны дагуу сумандаа 400 хүний суудалтай шинэ Соёлын төвтэй болох хүсэлтээ сумын Засаг даргад хүргүүлснээр шинэ Соёлын төвийн зураг төсвийг Дархан-Уул аймгийн Ноёдын туурь ХХК зураг төсвийн ажлыг хийгдсэн. 2024 онд улсын төсөвт 3,8 тэрбум төгрөгөөр 400 хүний суудалтай шинэ Соёлын төв баригдахаар улсын төсөвт батлагдаж барилга баригдаж эхэлсэн. Барилгын үйл явц 50%-тай байна. | 100 |
| 23 | “Бид Сэлэнгийн үр сад”, “Эв модны наадам”, “Алтаргана” зэрэг томоохон урлаг, соёлын арга хэмжээнүүдэд оролцож, хүүхэд залуучууд, уран бүтээлчдийг дэмжиж ажиллана. | Хөтөл хотноо болсон “Бүжгийн ертөнц-2024” Аймгийн аварга шалгаруулах бүжгийн тэмцээнд оролцохоор бэлтгэгдсэн хүүхдүүдийн шатахууны зардалд 400,000 мянган төгрөг,<br>- Ерөө бүсийн хүүхдийн урлагийн бага наадамд “Ачит оргил” ХХК-иас нийгмийн хариуцлагын хүрээнд 2 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн.<br>-2024 оны 07 сарын 20-ны өдөр Гадаадын хамтын ажиллагаа ОХУ-ын Буриад Улсын Зэдын аймагт жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "БОРГОЙСКАЯ БАРАНИНА" хонины найр наадамын нээлтийн үйл ажиллагаанд Соёлын төвийн дэргэдэх бүжгийн “Сондор” хамтлагийн 13 хүүхэд, буриад дууны дугуйлангийн багш С.Оюун нар зэрэг Ерөө сумаас нийт 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцон Б100уриад зон олонд дуу хуур, ардын бүжгээр мэндчилгээ дэвшүүлж, мөн оройн үдшийн цэнгүүн, шоу арга хэмжээнд оролцож Монгол үндэсний соёл урлагаа сурталчлан ажилласан. Соёлын төвөөс уг арга хэмжээнд ирж,буцах замын зардал 750,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>-“Алтаргана-2024” наадамд оролцоход Сэлэнгэ аймгийн ЗДТГ-аас 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн. | 100 |
| | | -2024 оны жилийн эцсээр 267 том хүн, 490 хүүхэд, 6 гадаадын иргэн нийт 763 иргэнд Орон нутгийн музейг сурталчилсан байна.<br>- Ерөө сумын түүхт 100 жилийн ойг угтан орон нутаг сурталчилах танхимдаа 7 сая төгрөгний өртөг бүхий хорго, шилэн хаалга зэргийг хийлгэн байршуулж, шинээр | |

| | | | |
|---|---|---|---|
| 24 | Сумын орон нутаг судлах "Музейн үзмэр"-ийг баяжуулж нутаг орныхоо онцлог, түүх, соёлын онцлогийг сурталчлахын зэрэгцээ “Өв соёлын өргөө”-тэй болж монгол ахуй соёл, зан үйлийг хүүхэд багачууд, залуучууд, иргэдэд сурталчлан таниулна. | үзмэр дэглэлт хийсэн.<br><br>- Ерөө сумын зуун жилийн ойг угтан eruu100.mn вэб сайтыг 1,764,000 мянган төгрөгний өртөгөөр хийлгэж танилцуулга, мэдээ мэдээлэл, музей, түүхэн дурсгалт газрууд, Ерөө сум 100 жил, Ерөө сумын Хөдөлмөрийн баатрууд, Холбоо барих гэсэн 7 үндсэн цэсэнд нийт 94 текстэнд мэдээлэл, 46 видео мэдээлэл, 16 зурган мэдээ мэдээллүүдийг байршуулан ажилласан байна.<br><br>- Ерөөгийн халуун рашаан, нийслэлийн суурь зэрэг газрын дүрст танилцуулгыг байгууллагын цахим хаягнаас олон нийтийн сүлжээнд байршуулан сурталчилсан.<br>- Eruu100.mn вэб сайтд Ерөө сумын түүхэн дурсгалт газруудын дэлгэрэнгүй зурган мэдээллийг байршуулсан.<br><br>- Ерөө сумын түүхт 100-н жилийн ойг угтан “Хилэнт эх” хэмээх модон луу жилийн “Цагаан сар”-ын баярыг тохиолдуулан Улсын тэргүүний 1-р Цэцэрлэгийн 8 бүлгийн 159 хүүхдийн дунд Уламжлалт шагайн наадгай /морь уралдуулах/, Би ерөөж чадна /уран уншлагын тэмцээн/, Хамгийн сайхан дээлтэй хүүхэд зэрэг тэмцээнийг зохион явуулсан.<br><br>- “Малчдын баяр-2024” арга хэмжээний үеэр өв соёлоо түгээн дэлгэрүүлэх, сурталчилах зорилгоор “МОНГОЛ ГЭР ХЭРХЭН БАРИХ ВЭ” тэмцээнийг зохион явуулсан. Тэмцээнд 22 иргэн оролцон 3 байр шалгаруулан шагнасан.<br><br>- "СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР-2024" “Буриад өв соёл” нэрийн дор бруиад хоол хүнс болон буриад үндэстний хувцасны талаарх 2 төрлийн контент бэлтгэн “Сэлэнгэ Ерөө Соёлын төв” фэйсбүүк хуудсаар цацсан. Хандалтын тоо:1400<br><br>- "СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР-2024" аяны хүрээд Нүүдэлчин соёлтой Монголчуудын эртнээс тоглон уламжлагдан ирсэн "ШАГАЙ НААДГАЙ" тэмцээнийг сумын ахмад настнуудын дунд амжилттай зохион явуулсан. Тэмцээнийг алаг мэлхий өрөх, морь уралдах, шагай шүүрэх гэсэн төрлөөр зохион явуулж 3 байр шалгаруулан шагнаж урамшуулсан байна.<br><br>- "СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР-2024" аяны хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Ерөө сумын аварга шалгаруулах "АДУУЧИН" тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд нийт 20 адуучин 4 төрлөөр өрсөлдөж шилдэг 3 адуучин шалгаран шагнагдсан.<br><br>- Өв соёлын өргөөнд шагайн харвааны ком 1 сая төгрөгөөр худалдан авсан. | 100 |
| | | -Хөтөл хотноо болсон “Бүжгийн ертөнц-2024” Аймгийн аварга шалгаруулах бүжгийн тэмцээнд оролцохоор бэлтгэгдсэн хүүхдүүдийн шатахууны зардалд 400,000 мянган төгрөг,<br>- Ерөө бүсийн хүүхдийн урлагийн бага наадамд “Ачит оргил” ХХК-иас нийгмийн хариуцлагын хүрээнд 2 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн. | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| 25 | Соёл урлагаар аймаг, улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлж, амжилт гаргасан иргэд, хүүхэд багачуудыг урамшуулна. | -2024 оны 07 сарын 20-ны өдөр Гадаадын хамтын ажиллагаа ОХУ-ын Буриад Улсын Зэдын аймагт жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "БОРГОЙСКАЯ БАРАНИНА" хонины найр наадамын нээлтийн үйл ажиллагаанд Соёлын төвийн дэргэдэх бүжгийн "Сондор" хамтлагийн 13 хүүхэд, буриад дууны дугуйлангийн багш С.Оюун нар зэрэг Ерөө сумаас нийт 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр оролцон Буриад зон олонд дуу хуур, ардын бүжгээр мэндчилгээ дэвшүүлж, мөн оройн үдшийн цэнгүүн, шоу арга хэмжээнд оролцож Монгол үндэсний соёл урлагаа сурталчлан ажилласан. Соёлын төвөөс уг арга хэмжээнд ирж,буцах замын зардал 750,000 төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>-"Алтаргана-2024" наадамд оролцоход Сэлэнгэ аймгийн ЗДТГ-аас 1 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.<br>- МУСТА П.Баасанбаа агсаны нэрэмжит "Ерөө нутгийн үрс" урлагийн наадмын үеэр сумын авьяаслаг сурагчаар 12А ангийн сурагч П.Ариунзаяа-г тодруулж ЦОМ, ӨРГӨМЖЛӨЛ, мөнгөн шагналаар шагнаж урамшуулсан. | |
| 26 | Малчин өрхүүдэд соёл урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулна. | - 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдөр "МАЛЧДЫН БАЯР-2024" зохион байгуулж үдшийн цэнгүүн явуулан ажилласан.<br>Соёлын төвийн дэргэдэх номын сангаас ном олгох үйлчилгээ үзүүлж, угийн бичгийн талаарх брошур тараан ажилласан.<br>Соёлын төвийн дэргэдэх Орон нутаг сурталчилах танхимаас "Монгол гэр хэрхэн барих вэ?" тэмцээнийг амжилттай зохион байгуулсан.<br>Мөн бөхийн барилдаан, соёолон насны морьдын уралдаан, малчдын дундах гар бөмбөгийн тэмцээнүүд болсон.<br>-"СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР-2024" аяны хүрээнд 2024 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Ерөө сумын аварга шалгаруулах "АДУУЧИН" тэмцээн амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд нийт 20 адуучин 4 төрлөөр өрсөлдөж шилдэг 3 адуучин шалгаран шагнагдсан. | 100 |
| 27 | Хүүхэд бүрийг бүтээлч сэтгэлгээтэй, нутгийнхаа түүх, байгалийн онцлог, соёл уламжлалаар бахархах эх оронч хүмүүжлийг олгох ажлыг зохион байгуулна. | -2024 онд ЕБС-ийн сурагч, Цэцэрлэгийн 490 хүүхдэд Орон нутаг судлах танхимыг сурталчилж, сум орон нутгийнхаа түүхийн талаар мэдээлэл өгсөн.<br><br>- Ерөө сумын түүхт 100-н жилийн ойг угтан "Хилэнт эх" хэмээх модон луу жилийн "Цагаан сар"-ын баярыг тохиолдуулан Улсын тэргүүний 1-р Цэцэрлэгийн 8 бүлгийн 159 хүүхдийн дунд Уламжлалт шагайн наадгай /морь уралдуулах/, Би ерөөж чадна /уран уншлагын тэмцээн/, Хамгийн сайхан дээлтэй хүүхэд зэрэг тэмцээнийг зохион явуулсан.<br><br>- Соёлын яамнаас 03 дугаар сарын эхний 7 хоногийг "Музейн нээлттэй өдөр" болгон зарласан. Уг хөтөлбөрийн хүрээнд Соёлын төвийн дэргэдэх Орон нутаг сурталчилах танхимаас Т.Бямбаагийн нэрэмжит ЕБС-ийн 7-р ангийн хүүхдүүдэд "Музей үзэх соёл" сургалтыг зохион байгуулсан.<br><br>- Дэлхийн гэр бүлийн өдрийг угтан зохион явуулсан "ХАЙР ДҮҮРЭН ГЭР БҮЛ" арга хэмжээнд аав ээжтэйгээ оролцохоор ирсэн бяцхан хүүхдүүдийн сэтгэлийн үгсийг | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | дүрсжүүлэн фэйсбүүк хуудсаар цацсан.<br>- Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр" Эцэг эхчүүдэд эерэг хүмүүжлийн арга сурталчилан Сумын Нийгмийн ажилтан Солонго-той хамтран нөлөөллийн контент бэлтгэн хүргэсэн.<br>- "Аяллын хөтөч" хүүхдүүд орон нутаг судлах танхимын тайлбарлагч хүүхэд бэлтгэх дугуйланг хичээллүүлж байна. | |
| 28 | Сумандаа "Өвлийн спорт"-ыг бодлогоор дэмжихийн зэрэгцээ үндэсний уламжлалт спортыг хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлнэ. | 2024 онд хойд бүсийн мөсөн сурын тэмцээн зохион байгуулахад 10,0 сая төгрөг, хоккейн тэмцээнд оролцоход зориулж 9,6 сая төгрөгийг тус тус зарцууллаа. | 100 |
| 1.4 Биеийн тамир, спортын бодлого | | | |
| Зорилт: Ард иргэд, хүүхэд залуучуудаа бялдаржуулан чийрэгжүүлж, эрүүлжүүлэх зорилт хэрэгжүүлнэ. | | | |
| 29 | Спортын төрлүүдээр аймаг, улсын чанартай уралдаан тэмцээнд оролцоход нь дэмжлэг үзүүлж удаа дараа амжилт гаргасан иргэд, хүүхэд багачуудыг "Урамшуулах бодлого"-ыг хэрэгжүүлнэ. Мөн сан байгуулах ажлыг эхлүүлнэ. | Сэлэнгэ аймгийн Ерөө хавкс баг Ю18 амжилттай оролцож хүрэл медаль хүртэж сумын засаг даргаас дасгалжуулагч нарт тус бүр 200000 мянган төгрөг 10 тамирчин сурагч нарт 100000 төгрөг шагнаж урамшуулсан. | 100 |
| 30 | Спортын төрлөөр үйл ажиллагаа явуулж буй салбар зөвлөл, клуб, төрийн бус байгууллагын үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллана. | Чөлөөт бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн зохион байгуулахад 10 сая, сурын холбоо мөсөн сурын улсын чанартай тэмцээн зохион байгуулхад 10 сая төгрөг, сурын дов цэц мэргэд холбоо багийн сурын аварга шалгаруулах тэмцээнд 40 сая төгрөг, Хоккейн спорын тэмцээний зардалд 9,6 сая төгрөг, үндэсний бөхийн холбоонд залуу бөхийн цуврал барилдаанд 1,0 сая төгрөгийг тус тус зарцуулж, дэмжлэг үзүүлсэн. | 100 |
| 31 | Сумандаа улс, аймаг, бүсийн чанартай тэмцээн уралдааныг зохион байгуулна. /Үндэсний бөхийн цуврал барилдаан, чөлөөт бөхийн аймгийн аварга шалгаруулах тэмцээн болон бусад/ | Ерөө сумын түүхт 100 жилийг угтан Сэлэнгэ аймгийн аварга шалгаруулах чөлөөт бөхийн тэмцээнд 12 сумын 246 тамирчид өрсөлдөж Ерөө сумын багийн дүнгээр эрэгтэй эмэгтэй түрүүлж цомын эзэн болж Д.Мягмарсүх шилдэг эмэгтэй тамирчин, Ерөө сумын Засаг дарга Б.Сэргэлэн чөлөөт бөхийн дээд шагнал ЯЛАЛТ одонгоор шагнагдсан байна<br>ӨСВӨР ҮЕИЙН ЧӨЛӨӨТ БӨХИЙН ОЛОН ХОТЫН ТЭМЦЭЭН АМЖИЛТТАЙ БОЛЖ ӨНДӨРЛӨЛӨӨ АБТА, БТТА, Спортын мастер Цэрэнжавын ЖИГДЭН агсны нэрэмжит Өсвөр үеийн чөлөөт бөхийн олон хотын тэмцээн энэ сарын 6,7-ны өдрүүдэд Дархан-Уул аймагт амжилттай зохион байгуулагдлаа. Тэмцээнд Улаанбаатар- Алдар спорт хороо, Дархан, Сэлэнгэ, Өмнөговь, Дорноговь, Говь-Алтай, Сүхбаатар зэрэг аймгуудаас гадна Хиагт, Улан-Үдэ, Өвөр Монголын нийт 24 клубын 370 гаруй тамирчид оролцлоо. Өсвөрийн тамирчдын ур чадвар, хүчийг сорьсон ширүүн өрсөлдөөн дунд өрнөсөн тэмцээний Шилдэг эрэгтэй тамирчнаар: ДАРХАН-ЭРХЭТ КЛУБЫН ТАМИРЧИН П.ХҮСЭЛ-ЭРДЭНЭ Шилдэг эмэгтэй тамирчнаар: АЛДАР СПОРТ ХОРООНЫ ТАМИРЧИН А.АМАР-ОРЧЛОН Багийн дүнгээр Нэгдүгээр байр, Алтан медалийг: Ё.БАТДАРХАН ДАСГАЛЖУУЛАГЧАЙ ДАРХАН-УУЛ АЙМГИЙН БТСГ, ДАРХАН-ЭРХЭТ КЛУБ, Хоёрдугаар байр, Мөнгөн | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | медалийг: Б.ЖАРГАЛСАЙХАН ДАСГАЛЖУУЛАГЧТАЙ ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БАГ, Гуравдугаар байр, Хүрэл медалийг: Э.ОДГАРАВ ДАСГАЛЖУУЛАГЧТАЙ СЭЛЭНГЭ аймгийн баг тус тус эзэллээ.<br>Сэлэнгэ аймгийн Мандал сумын Спорт цогцолбороос1-р дүгээр сарын 19-20 нд зохион байгуулагдсан Сэлэнгэ аймгийн хэмжээнд охидын 15 насны ангилалалд нийт 12 баг оролцож Ерөө сумын Ерөө хавкс баг тэргүүн байр эзэлж Н.Хулан шилдэг тоглогч болсон.<br>Монгол улсын сагсан бөмбөгийн холбооноос зохион байгуулсан Ю-16 насны Улсын аварга шалгаруулах тэмцээнд эмэгтэй 25-н баг оролцсон. Тус тэмцээнд хэсэгээс 1-р гарч хасагдах шатанд шалгарч 4\1 ийн нугалаанд 33-р сургуулийн багтай таарч 37-32-оор хожиж шигшээ 4-т шалгарч зөрдөг тоглолтонд Багануурын шигшээ багтай таарч 33-24 оор хожиж аваргын төлөө Эрхэт эрдэм багтай тоглон 35-44 ийн харьцаатай хожигдон МӨНГӨН МЕДАЛЬ хүртлээ. Уг тэмцээний шилдэг хамгаалан тоглогч –оор Бахытбек Толгонай , Шилдэг холбон тоглогч –оор Жавхлан Отгон-эрдэнэ нар тус тус шалгарлаа<br>Монголын өсвөрийн сагсан бөмбөгийн холбооноос зохион байгуулсан U16 Улсын аварга шалгаруулах тэмцээнээс Сэлэнгэ аймаг Ерөө сумын Т.Бямбаагийн нэрэмжит ЕБС -ийн үндэсний бөхийн холбоонд залуу бөхийн цуврал барилдаанд төсөв гаргаж оролцсон. | |
| 32 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын уралдаан тэмцээнийг дэмжиж ажиллана. | Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн спортын Сэлэнгэ аймгийн аварга шалгаруулах тэмцээнд засаг даргын зүгээс тэмцээнд оролцох замын зардалд дэмжлэг үзүүлсэн | 100 |
| 33 | 3-р баг, Бугант тосгоны Спорт заалны барилгын ажлыг эхлүүлнэ. | Бугант тосгон барих спорт цогцолборын зураг төсвийг бэлэн болгосон. | 30 |
| 34 | Өвлийн спортыг хөгжүүлэхийг дэмжиж, орчныг бүрдүүлэн иргэд, ААНэгжүүдтэй хамтран ажиллана. | Залуучуудын аварга шалгаруулах хоккейн тэмцээн-2024 Бугант тосгонд 2024.01.05-07-ны өдрүүдэд зохион байгуулагдаж өндөрлөлөө. 1 дүгээр байр Г.Мөнхтулга дасгалжуулагчтай Ц.Эрдэнэбаяр ахлагчтай Бугант залуучууд баг өргөмжлөл, алтан медаль, мөнгөн шагнал, цомын эзэд 2 дугаар байр Б.Мөнхтогтох дасгалжуулагчтай Ч.Пүрэвочир ахлагчтай Шарын гол баг өргөмжлөл, мөнгөн медаль, мөнгөн шагнал 3 дугаар байр Б.Алдармөнх дасгалжуулагчтай Б.Шинэгэрэл ахлагчтай Бугант ЕБС баг өргөмжлөл, хүрэл медаль, мөнгөн шагнал ШИЛДЭГЭЭР Шарын гол багийн 19 номертой тамирчин Ч.Батбилгүүн шилдгийн шилдэг тоглогчоор шалгарч цом, мөнгөн шагнал Бугант Залуучууд багийн 7 номертой тамирчин Э.Ууганбаяр шилдэг довтлогчоор шалгарч цом, мөнгөн шагнал Дархан багийн 19 номертой тамирчин ОУХМ Д.Буянтогтох шилдэг хамгаалагчаар шалгарч цом, мөнгөн шагнал Бугант Залуучууд багийн 1 номертой тамирчин Ц.Төрбат шилдэг хаалгачаар шалгарч цом, мөнгөн шагналаар тус тус шагнагдлаа<br>Улаанбаатар хотноо болсон 2024 оны Монгол туургатны мөсөн сурын харвааны аварга шалгаруулах тэмцээнд 19 аймгийн 520 тамирчин, БНХАУ-ын Өвөрмонгол, Шинжаан Уйгур, ОХУ-ын Бүгд найрамдах Буриад улс, Бүгд найрамдах Тува улсын | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | 34 тамирчин цэц мэргэнээ сорин харвалаа Тэмцээнд : -р байр эзэлсэн Аймгийн мэргэн, спортын мастер П.Эрдэнэчулуун ахлагчтай Сэлэнгэ аймгийн Ерөө сумын "Хан Буурагчингийн мэргэд" клубын харваачид М.Эрхэмбаяр, У.Энхбаяр, Х.Батдорж | |
| 35 | “Захирагчийн цом” иргэдийн спортын наадмыг зохион байгуулна. | “ЗАХИРАГЧИЙН ЦОМ 2024” 5н төрөлт спортын эв нэгдлийн наадам 7 дахь жилдээ амжилттай зохион байгуулагдлаа | 100 |
| 1.5 Гэр бүл, хүүхэд залуучуудын бодлого | | | |
| Зорилт: Гэр бүл бүхэн өөрийн үнэт зүйлсээ дээдлэн хөгжүүлж, үр хойчдоо уламжлан үлдээж өвлүүлнэ. | | | |
| 36 | Шинэ залуу гэр бүл, болон зорилтот бүлгийн иргэд, төр, төсвийн байгууллагын албан хаагчдыг “Орон сууцжуулах” бодлогыг хэрэгжүүлэн ажиллана. | Засаг даргын тамгын газрын хөрөнгөд бүртгэлтэй 3 байрыг төсвийн байгууллагын албан хаагчдыг орон сууцжуулахад зорилгоор түр эзэмшүүлж байна. /Сургууль 2 байр, цагдаа 1 байр/, Мөн төрийн албан хаагчдыг орон сууцжуулахаар соёлын төвийн ажилтан Ш.Дарьсүрэн, цэцэрлэгийн багш Л.Батчимэг нарт байшингийн мод олгосон. | 90 |
| 37 | “Хамтарсан баг”-ийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, “Түр хамгаалах өрөө”-г байгуулна. | Ерөө сумын ИТХ-ын 2023 оны 114 дүгээр тогтоолоор Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар Түр хамгаалах өрөөний засварыг 10 сая, өрөөний тохижилтийн ажилд 10 сая төгрөг төсөвлөгдөн батлагдсан ба түр хамгаалах өрөөний засварыг “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГазар, тохижилтын ажлыг “Анагаагч зөгий” ХХК гүйцэтгэн 100 хувь хүлээлгэн өгсөн. Үүний үр дүнд Түр хамгаалах өрөөний үйл ажиллааа эхлэж насанд хүрсэн хүн 2, бага насны 2 хүүхдийг учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлж түр хамгаалах байранд байрлуулж хамгаалсан. | 100 |
| 38 | Хүүхэд, гэр бүлд чиглэсэн нөлөөллийн ажлыг зохион байгуулж, эцэг эхийн үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлж гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд зохион байгуулна. | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр Ерөө сумын хамтарсан баг нь сумын Засаг даргын баталсан Хамтарсан багийн 2024 оны ажлын төлөвлөгөөнд заасан 28 төрлийн ажил арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бусаар нийтдээ 8 удаа хуралдаж 19 дуудлага, мэдээлэл дээр ажилласан.<br>Хүчирхийллийн болзошгүй эрсдэлтэй гэр бүлийг илрүүлэх, мэдээлэх, хүчирхийллийг таслан зогсоох, үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлэх зорилгоор судалгаа явуулж Тавин, Буурагчин багийн 16 иргэнийг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй судалгаанд оруулж тус бүрчлэн хувийн хэрэг нээн өрх бүр дээр төлөвлөгөө гарган ажилласнаар 4 иргэн гэр бүлийн хүчирхийлэл үйлдэхгүй гэр бүл нь хэвийн тогтвортой байна. Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэгдсэн 4, эрүүгийн хуулиар шийдвэрлэгдсэн 2, Эрүүгийн хэрэг үүссэн 2 тохиолдол мөн 3 иргэнийг Хамтарсан багийн хурлаар оруулан ажилласан. Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлснээр эрсдэл 25 хувиар буурсан. | 100 |
| 39 | Архины хамааралтай өрх, иргэнд чиглэсэн арга хэмжээнүүдийг шат дараатай авч хэрэгжүүлнэ. | Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 7 өрхтэй ажиллан СЭМҮТ-д 2 иргэнийг, аймгийн нэгдсэн эмнэлэгт 1 иргэнийг холбон зуучилж, 5 иргэнд шууд нөлөөлөн ажилласнаар 4 иргэн архины хамаарлаас гарч 3 иргэн ажиглалтад, 1 иргэн оршин суугаа байршилаа өөрчилсөн үр дүнд хүрсэн. | 100 |
| 40 | “Тэргүүний өрхийн аж ахуй, “Бүтээлч айл өрх”, “Соёлч өрх”, -ийг шалгаруулж туршлагыг нь түгээн дэлгэрүүлж, иргэд бие | “Цагаан сар” нэгдсэн арга хэмжээний үеэр Сумын шилдэг өрхийн үйлдвэрлэгчээр 3 өрх, сумын аварга фермерээр 2 өрхийг тус тус шалгаруулан олон нийтэд таниулан ажилласан. | |

| | | | |
|---|---|---|---|
| | биенээсээ суралцах боломжийг бүрдүүлнэ. | | |
| 41 | “Иргэдийн оролцоо Ерөөгийн хөгжилд” иргэдээ соён гэгээрүүлэх ажлыг жилдээ 1 удаа зохион байгуулна. | Иргэдээ соён гэгээрүүлэх ажлын хүрээнд 7 арга хэмжээ зохион байгуулж 596 иргэн хамруулж 9,3 сая төгрөгийг зарцуулан ажилласан. Тухайлбал “Өвөл цагийн соёл хүмүүжлийн ажил”, Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдөр, Цэргийн баяр, Угийн бичгийн сургалт, “Тансаг цэцэг таны хашаанд” сургалт, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сургалт зэрэг арга хэмжээнүүдийг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. | 100 |
| 42 | ТББайгууллагуудтай хамтарч ажиллах /Эмэгтэйчүүдийн холбоог байртай болгох/ | Сургуулийн 2-р байрыг ашиглах боломжийг ТББайгууллагуудад танилцуулсан. Байр ашиглалттай холбоотой урсгал зардалыг санаачлагч байгууллага /ТББ, холбоо/ хариуцах боломжгүй шалтгаанаар тус ажил хэрэгжээгүй | 0 |
| 1.6 Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгаалал | | | |
| Зорилт:Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, орлого олох боломжийг бүрдүүлнэ. | | | |
| 43 | Жил бүр ажилгүй иргэдийн судалгааг үндэслэн орон нутгийн бүтээн байгуулалтын ажлын эрэлт хэрэгцээнд тулгуурлан мэргэжилтэй боловсон хүчинг бэлтгэх ажлыг зохион байгуулж хэрэгжүүлнэ. | 2024.02.05-13-ны хооронд Дархан уул аймгийн Ла Лу НА сургалтын төвийн сургагч багш Ерөө суманд байрлаж уул уурхайн өргөн мэргэжил олгох сургалтыг явуулж 15 иргэн хамрагдан хүнд машин механизмын оператор, баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн оператор, хүнд машин механизмын засварчин, эксковаторын опертор, шанагт ачигчын оператор гэсэн мэргэжлүүдээр мэргэжлийн үнэмлэх сертификатыг гардан авсан ба үүнээс 12 иргэн БТЕГ ХХК болон Инфинийти Спейс ХХК-нд байнгын ажлын байранд зуучлуулан ажил д орж тогтмол орлоготой болсон байна. | 100 |
| 44 | Сумын хэмжээнд байгаа мэргэжилтэй боловсон хүчинг ажлын байранд зуучилж, ажилтай, орлоготой болгох зорилгоор “Нэг өрх-нэг ажлын байр” хөтөлбөрийг хэрэгжүүлж ажилгүйдлийг багасгаж, өрхийн үйлдвэрлэлийг дэмжиж ажиллана. | Уул уурхайн салбар, газар тариалангийн 6 аж ахуй нэгж байгууллага, төр төсвийн 7 байгууллагт 125 иргэн ажил горилогчийн анкет бөглөж 83 иргэн шинэ ажлын байранд. 60 иргэн байнгын ажлын байранд зуучлуулан орж тогтмол цалин, орлоготой болсон байна.<br>2024-2025 онд хэрэгжих төсөл хөтөлбөрүүдээс суманд ирсэн квотын дагуу иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 1, ХБИргэнийг дэмжих хөтөлбөрт 7, ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 5 иргэдийн төслийг тус тус хүлээн авсан бөгөөд үүнээс иргэнд олгох санхүүгийн дэмжлэгт 2-р багийн иргэн О.Мягмарсүрэн “Ерөө амтлаг хэмх” төсөл 8 сая төгрөг, Ахмад настан Б.Оюунцэцэг “Амин дэм” төсөл 3 сая төгрөг, ахмад настан Г.Батдолгорын “Уран холбоос” төсөл 6 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн Ц.Баяржаргалийн “Авто засвар”-ын үйл ажиллагаа эрхлэх төсөл 8 сая төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн С.Буяндалайгийн “Модон эдлэлийн мужаан” төсөл 6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг тус тус авч үйл ажиллагаагаа өргөтгөн тоног төхөөрөмжөө сайжруулж 8 байнгын ажлын байр бий болголоо. | 100 |
| 45 | Амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой зорилтот бүлгийн өрхийг “Малжуулах, туслах аж ахуй эрхлэх” нөхцөл | Малжуулахын санхүүгийн дэмжлэгт 2 иргэн хүсэлт өгч М.Айбекын төсөл шалгаран хүүгүй, барьцаагүйгээр 8 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамрагдан 4 тугалтай үнээ болон 2 охин бяруу, нийт 10 толгой эм үхэр худалдан авч малаа өсгөн үржүүлэхээр боллоо.<br>Мөн Мандал суманд болсон малын ашиг шим хэрхэн зөв боловсруулах | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | боломжоор хангаж амьжиргааны эх үүсвэртэй болгоно. | тухай сургалтанд М.Айбек хамрагдаж ур чадварыг нотлох сертификат авсан байна. | |
| 46 | Өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд үндэслэн нийгмийн халамжийн үйлчилгээг зорилтот бүлэгт чиглүүлэн өрхийн амьжиргааг дэмжиж ажиллана. | Энэ онд өрхийн амьжиргааны түвшин тогтоох судалгаанд хамрагдах хүсэлт ирээгүй. Ерөө суманд хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагдаж байсан 4 өрхийн амьжиргааны түвшин дээшилж /байнгын ажлын байртай болсон/ тус үйлчилгээг зогсоосон. | 100 |
| 47 | Иргэдийг сайн дурын даатгалд хамруулах ажлыг зохион байгуулах | Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд нийт 267 иргэн хамрагдаж үүнээс малчин 121, ажил хөдөлмөр эрхлээгүй иргэн 114, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 24, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа ажил хөдөлмөр эрхлээгүй эх /эцэг/ -8 иргэн байна. | 100 |
| 48 | Эрүүл мэндийн даатгалд хамрагдагсдын хувийг нэмэгдүүлж хөдөлмөр эрхэлдэггүй иргэн, ХХЭрхлэгч, малчдыг хамруулна. | 2024.10.30 ны байдлаар малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, оюутан суралцагчаас эрүүл мэндийн даатгалд 471 даатгуулагч хамрагдаж 44915,9 мянган төгрөгийн орлогыг санд бүрдүүлэн ажилласан байна. | 100 |
| 2. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | |
| 2.1 Мэргэшсэн, ёс зүйтэй, иргэнд ээлтэй төрийн алба | | | |
| Чадварлаг, ухаалаг, хүртээмжтэй, нээлттэй засаглалын тогтолцоог бэхжүүлнэ. | | | |
| 49 | Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх , иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх чиглэлээр төрөл бүрийн ажил үйлчилгээг нэвтрүүлж, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг *“нийтэд ил тод, нээлттэй, хяналттай болгоно”*. | Eruu.se.gov.mn вэб сайтын шинэчлэлийг “Mind agency” ХХК-тай 100 хувь гүйцэтгүүлэн ашиглалтад оруулж төрийн үйлчилгээ, зохион байгуулсан ажлын мэдээллийг нийтэд нээлттэй ил байршуулан ажилласан. цахим сайтаар 102 мэдээ мэдээллийг байршуулж, шилэн данс, tender.gov.mn сайт, ЗДТГ-ын мэдээ фэйсбүүк хаягаар мэдээллийн чанартай пост 652, Сэтгэгдэл 3205, хандалт 22010 байна. | 90 |
| 50 | Төрийн албан хаагчдын ёс зүйн хэм хэмжээг дээшлүүлж, хариуцлага , үр дүнг тооцох арга хэлбэрийг сайжруулж, мэдлэг, хандлагад суурилсан *“мэргэшсэн төрийн албан хаагч”*-даар бүрдүүлж ажиллана. | “Төрийн албан хаагчдын зөвлөгөөн-2024” арга хэмжээг зохион байгуулж сумын хэмжээнд нийт 133 төрийн албан хаагчдыг хамруулан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай” хуулийн талаарх мэдлэг мэдээллийг олголоо.<br>Сумын ЗДТГ-н ёс зүйн дэд хороо нь нийт төсвийн байгууллагуудын ёс зүйн дэд хорооны судалгаа мэдээллийг нэгтгэн гаргаж 2024 онд 4 удаагийн хурал, 2 удаагийн арга хэмжээг зохион байгуулан ажилласан. Ёс зүйн дэд хороонд 1 өргөдөл гомдол ирснийг өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах арга хэмжээг тус тус авч ажилласан.<br>Тайлант онд сахилгын болон ёс зүйн зөрчил гарган хариуцлага тооцуулсан албан хаагч байхгүй. | 90 |
| | | Иргэний бүртгэлийн чиглэлээр:<br>Тайлант онд 158 иргэнд тоон гарын үсэг олгосон ба сумын нийт 1510 иргэн буюу 80 хувь нь тоон гарын үсгээ авсан.<br>-Төрсний, Үрчлэлтийн, ОНӨ-ийн,Гэрлэлтийн, Гэрлэлт цуцлалтын, Нас барсны, Шилжилт хөдөлгөөний, ИШБ-ийн, гадаад паспортын нийт 501 бүртгэлийн 820 | |

| | | | |
|---|---|---|---|
| 51 | Төрийн үйлчилгээг чирэгдэлгүй , шуурхай хүргэх, иргэдэд мэдээ мэдээллийг цаг алдалгүй мэдээлэх зорилгоор *“Цахим Ерөө”* хөтөлбөрийг хэрэгжүүлж, төрийн үйлчилгээний чанар хүртээмж, үр дүнг дээшлүүлнэ. | хуудас эх нотлох баримтын бүрдүүлбэрийг ханган бүрэн цахимжуулсан.<br>Хур систем буюу e.mongolia.mn цахимаар олгосон үйлчилгээ:<br>Нийтдээ 342 лавлагаа үйлчилгээг иргэдэд үзүүлсэн. Мөн гар утасны e.mongolia аппликейшн ашиглан 195 иргэнд лавлагаа мэдээллийг авах заавар зөвлөмжийг хүргэсэн.<br>Сэлэнгэ аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс тавьсан хүсэлтийн дагуу Төрийн үйлчилгээний “Хурдан” цэгийн хаягжуулалтын ажлыг хийж гүйцэтгэн 300,000 төгрөгийг зарцууллаа.<br>Газар тариалангийн чиглэлээр:<br>Plant.mof..gov.mn газар тариалангийн цахим системээр 14 аж ахуйн нэгж, 15 иргэнд үр тариа болон хүнсний ногооны цахим гарал үүслийн гэрчилгээ бичигдсэн.<br>Нийгмийн халамжийн чиглэлээр:<br>Нийгмийн халамжийн үйлчилгээг бүртгэх www.ehalamj.mn халамжийн нэгдсэн системээр 1450 хүүхэд, 9 ахмад настан, 75 иргэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, 16 хүүхэд тэжээгчээ алдсаны тэтгэмж, 194 иргэн асаргааны тэтжгэмж, 7 өрх толгойлсон эцэг эхийн тэтгэмж, 1 иргэн алдар цолтон, 175 цалинтай ээж, 50 жирэмсэн ээж, 234 иргэн, насны хишиг, 292 ээж алдарт эхийн одонгийн үйлчилгээнд хамрагдаж нийт 2503 иргэний үйлчилгээ бүртгэгдэж сар бүр тодорхой хугацаанд санхүүжилтийг тогтмол олгож байна.<br>Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн Www.office.ejob.gov.mn сайтаар хөдөлмөр эрхлэлттэй холбоотой шинэ ажлын байр болон зуучлал, ажлын байрны захиалгыг тогтмол бүртгэж байна. Энэ онд ажил зуучлал-90, шинэ ажлын байр 118 үүнээс 71 нь сумын иргэд, 47 нь Сэлэнгэ аймаг болон бусад сумдаас манай сумын нутаг дэвсгэрт байгаа аж ахуйн нэгж байгууллагад шинээр ажилд орсон иргэдийн тоо юм. АМЧБО-40, суурь ур чадвар олгох сургалт 23, Ажил хайгч иргэн 178, пропайлинг үйлчилгээнд 45 иргэн, ажилгүйдлийн тэтгэмжид 53 иргэн нийт давхардсан тоогоор 547 иргэн хамрагдаж ижоб программд бүртгэгдсэн байна.<br>Нийгмийн даатгалын үйлчилгээ цахимжсанаар:<br>• Жирэмсэн амаржсаны тэтгэмж -24,<br>• ХЧТА- давхардсан тоогоор-870 гаруй.,<br>• Ажилгүйдлийн тэтгэмж- 68<br>• Сайн дурын даатгалын гэрээ шинэ-132, гэрээ сунгалт-135 иргэнд тус тус цахимаар үйлчилгээ үзүүлсэн.<br>Газрын харилцааны чиглэлээр:<br>Тайлант хугацаанд газрын кадастрын цахим системээр дамжуулан нийт 380 өргөдлийг шийдвэрлэсэн. Шийдвэрлэсэн өргөдөл хүсэлтийг өргөдлийн төрлөөр нь ангилан авч үзвэл дараах байдалтай харагдаж байна.<br>• Шинээр газар өмчлөх -24<br>• Шинээр газар эзэмших - 31<br>• Дуудлага худалдаагаар газар эзэмших -6<br>• Газар эзэмших эрхийн гэрчилгээ нөхөн авах -1<br>• Худалдах худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчлөх-81 | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | • Газар эзэмших эрхийн гэрчилгээг барьцаанд бүртгүүлэх -172<br>• Газар эзэмших эрхийг бусдад шилжүүлэх - 22<br>• Газрын зориулалт өөрчлөх -1<br>• Эзэмшил газрын талбайн хэмжээ өөрчлөх -2<br>• Төсөвт байгууллагын зайлшгүй хэрэгцээнд -3<br>• Газрын кадастрын системд нөхөн бүрдүүлэх -37<br><br>www.ehalamj.mn | |
| 52 | Төрийн албан хаагчдын ажлын арга туршлагыг харилцан солилцох бие биенээсээ суралцах боломжийг бүрдүүлж ажиллана. | Жил бүр уламжлан болгон зохион байгуулагддаг "Ерөө бүсийн төрийн албан хаагчдын спортын нөхөрсөг уулзалт, тэмцээн"-н 05-р сард Жавхлант суманд зохион байгуулагдаж манай албан хаагчид 2-р байр эзэлсэн амжилттай оролцлоо.<br>10 дугаар сарын 18-ны өдөр Алтанбулаг сумын Засаг даргын Тамгын газрын хамт олон Ерөө суманд ирж байгууллагын үйл ажиллагаатай танилцлаа.<br>Мөн Санхүү албаны хамт олон Цагааннуур сумын Санхүү албатай туршлага судлах уулзалтыг зохион байгууллаа. | 100 |
| 53 | Төрийн албан хаагчдын ажиллах нөхцөл , нийгмийн баталгааг эрэлт, хэрэгцээ, нийгмийн шаардлагад нийцүүлэн сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж төр, төсвийн байгууллагын *"шинэ залуу боловсон хүчнүүдийн нийгмийн асуудал"*-ыг бодлогоор дэмжиж тогтвор суурьшилтай ажиллах боломжийг бүрдүүлэн, 6 хүртэлх төрийн албан хаагчийг орон сууцжуулах, төсөл хөтөлбөрт хамруулах ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлж ажиллана. | Тайлант онд төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор:<br>• "Цахим төрийн албан хаагч" -Аймгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 166 сая төгрөгийн тендерт "Хос анар"ХХК 154 сая төгрөгөөр шалгарч Ерөө сумын ЗДТГ болон Захирагчийн албанд 30ш компьютер, 30ш ширээ шүүгээний хамт, 2 хурлын ширээ, 85 инчийн ухаалагч дэлгэц, 3 түргэн скайнер, 2 хэвлэгчийн хамтаар нийлүүлсэн.<br>• "Чанарын менежментийн тогтолцоо ISO:9001" Олон улсын стандарцыг суманд хэрэгжүүлэх зорилгоор 15,0 сая төгрөгийн өртөгтэй сургалтад байгууллагын 15 албан хаагч.,<br>• "POWER BI EXCEL" сургалтыг 3 өдрийн хугацаанд "Think pro LLC" ХХК-тай хамтран сумандаа зохион байгуулж 20 албан хаагчийг хамруулан 4,0 сая төгрөг.,<br>• Орон нутагт ажилласны нэмэгдлийг төрийн захиргааны, үйлчилгээ, улс төрийн албан хаагчдад 30 хувиар тооцон сар бүр.,<br>• Нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэлгийг 22 албан хаагчдад 3,600,000 төгрөг.,<br>• ЗДТГ-н 22 ажилтан албан хаагчдыг Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулан 2,0 сая төгрөг.,<br>Ажиллах орчин нөхцлийг сайжруулах зорилгоор нийтдээ 20,0 сая төгрөг төсөвлөж ЗДТГ-н байрны дотор засал, хувцас хадгалах шүүгээ, албан хэрэгцээнд өнгөт принтер, дугуйтай сандал зэргийг худалдан авч орчин нөхцлийг сайжруулан ажиллаж байна.<br>Суралцагч байгууллага-төрийн албаны манлайлалын хүрээнд:<br>• Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулагддаг долоо хоног бүрийн Пүрэв гарагийн 7:4:10 цахим вебинар 17 удаагийн сургалтад давхардсан тоогоор 660 албан хаагч.,<br>• Засаг даргын Тамгын газрын "Өглөөний сонсгол" мэдээллийн цагаар ажилтан, албан хаагчид өөрийн эрхлэх асуудлын хүрээнд болон хууль эрх | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | зүйн мэдлэг мэдээлэл олгох 32 удаагийн сургалтад давхардсан тоогоор 736 албан хаагч., Бусад салбар салбарын мэдлэг, мэдээлэл олгох 15 удаагийн сургалтад давхардсан тоогоор 423 албан хаагч тус тус хамрагдсан байна. | |
| 54 | Газар өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбогдсон мэдээллийн ил тод байдлыг хангаж, *“шинээр өмчлүүлэх ажлыг эрчимжүүлж”,* газрыг эдийн засгийн эргэлтэд оруулна. | Газар өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбоотой цахимаар газар эзэмших хүсэлт илгээх, газрын цахим системээс үзүүлэх төрийн үйлчилгээ, хаягийн мэдээллийн систем зэрэг газрын харилцааны талаарх цаг үеийн мэдээ мэдээллийг сумын Засаг даргын Тамгын газрын мэдээ болон Ерөө сумын газрын даамал цахим хуудсуудаар иргэд олон нийтэд нээлттэй хүргэж ажилласан. 2024 онд иргэдэд өмчлүүлэх газрын зориулалт, хэмжээ, байршлыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлэн 2023 оны 11 сарын 01-ний өдрийн 105 тоот тогтоолыг батлуулсан. Иргэнд 2024 онд өмчлүүлэх газрын нийт хэмжээ байршил зориулалтыг тогтоох тухай Монгол улсын Засгийн газрын 2024 оны 04 сарын 03-ны өдрийн 137 дугаар тогтоол батлагдан гарснаас хойш цахим сүлжээнд зар мэдээллийг байршуулан хүсэлт гаргасан 24 иргэнд 4.78 га буюу 67 сая төгрөгийн үнэ бүхий газрыг нэг удаа үнэ төлбөргүй өмчлүүлж газрыг эдийн засгийн эргэлтэд оруулаад байна. | 100 |
| 55 | Сумын газар эзэмшүүлэх, ашиглуулах “дуудлага худалдааны үйл ажиллагааг олон нийтэд ил болгож”, цахим биржийн үйл ажиллагааг бүрэн нэвтрүүлнэ. | Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний дагуу 17 байршилд дуудлага худалдааг сумын Засаг даргын 3 удаагийн захирамжаар зарлан цахим биржээр нээлттэй явуулж 6 иргэнтэй ялагчийн гэрээ байгуулж, гэрээ гэрчилгээ олгон ажилласан. Ерөө сумын хувьд цахим биржийн үйл ажиллагаа бүрэн нэвтрээд байна. | 100 |
| 56 | Иргэдийн эрхзүйн боловсролыг дээшлүүлэх ажлын хүрээнд “Нийтийн сонсголын цаг” арга хэмжээг улирал тутамд зохион байгуулж, иргэдэд хууль, эрх зүйн мэдлэгийг олгоно. | “Иргэдтэй уулзах уулзалт” арга хэмжээг 9 удаа зохион байгуулан 771 иргэний хамруулан “2021-2023 онд хийгдсэн хөрөнгө оруулалт”, 2024 онд хийгдэх хөрөнгө оруулалт болон бусад цаг үеийн өвөлжилт, хаваржилтын байдалтай танилцан харилцан ярилцаж санал, хүсэлтийг сонсож ажиллалаа. | 100 |
| 57 | Монгол бичгийн хэрэглээний орчныг бүрдүүлж, хүүхэд багачууд, иргэдэд эзэмшүүлэн “Үндэсний бичгээрээ уншиж, бичицгээе 2021-2025” аяны хүрээнд арга хэмжээ зохион байгуулна. | “Угийн бичиг хөтлөх арга зүй, ач холбогдол” сэдвээр Угийн бичгийн академийн Сэлэнгэ аймгийн салбар зөвлөлийн захирал Б.Дүнгээг урьж үйлчилгээ үзүүлэх гэрээгээр төр төсвийн байгууллагын 75 албан хаагчид, иргэдэд сургалт зохион байгууллаа. Уг ажилд 379,500 төгрөгийг зарцуулсан.<br>Угийн бичиг хөтөлдөг иргэдээс өрхийн угийн бичиг хөтлөлт, өөрсдийн угийн бичгийг хэрхэн хөтөлдөг, ямар ач холбогдолтой талаар малчин А.Ширзагд, ахмад багш Б.Цэцгээ нарын 2 гэр бүлийг сонгон ЗДТГ-тай хамтран ярилцлага хийж цахим мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд түгээн ажилласан ба үзэгчдийн хандалт нийт 9600 иргэнд хүрсэн байна.<br>• Номын сангаас “Угийн бичиг хөтлөхийн ач холбогдол”-ын талаарх 45ш боршур, “Угийн бичиг хөтөлцгөөе” сэдэвт угийн бичгийн талаарх товч мэдээллийг агуулсан 40ш боршур нийт 85 ш боршурыг номын сангаар үйлчлүүлж буй иргэдэд тараасан.<br>2024 оны 11 дүгээр сарын 14-ны өдөр Т.Бямбаагийн нэрэмжит ЕБС-ийн багш Д.Батжаргал багш “Ургийн бичиг хөтөлж ирсэн уламжлал” сэдвээр 7-р ангийн | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | сурагчдад мэдээлэл өгч, сургалт зохион явууллаа<br>“Малчдын баяр-2024” арга хэмжээний үеэр Соёлын төвийн дэргэдэх номын сангаас ном олгох үйлчилгээ үзүүлж, угийн бичгийн талаарх брошур тараан ажилласан. | |
| 58 | Төрийн үйлчилгээний “Хур” болон e-mongolia системээр дамжуулан иргэдэд лавлагаа мэдээллийг үзүүлж төрийн үйлчилгээг ойртуулна. | Төрийн үйлчилгээний операторaac Төрийн үйлчилгээний e-mongolia буюу Хур системээр дамжуулан иргэдэд лавлагаа мэдээллийг тогтмол олгон ажиллаж байна. Тайлант хугацаанд :<br>• Нийгмийн даатгалын лавлагаа-139<br>• Иргэний оршин суугаа хаягийн бүртгэлийн лавлагаа-49<br>• Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байсан эсэх тодорхойлолт-11<br>• Иргэний үнэмлэхийн лавлагаа-79<br>• Үл хөдлөх эд хөрөнгө шилжүүлэх-3<br>• Үл хөдлөх хөрөнгийн лавлагаа-21<br>• Зээлийн мэдээллийн лавлагаа-5<br>• Газрын кадастр-1<br>• Нотариатаар гэрчлүүлсэн үйлдлийн хуулбар-3<br>• Төрсний бүртгэлийн лавлагаа-18<br>• Малын А данс-1<br>• Жолоочийн лавлагаа-1<br>• Шүүхийн шийдвэрээр бусдад өр төлбөргүй эсэх тодорхойлолт- 5<br>• Дээд боловсролын гэрчилгээ- 1<br>• Малчны тодорхойлолт-2<br>• Иргэний эрүүгийн хариуцлага хүлээж байгаа тодорхойлолт-1<br>• Гэрлэсний бүртгэлийн лавлагаа- 2<br>Нийтдээ 342 лавлагаа үйлчилгээг иргэдэд үзүүлсэн. Мөн гар утасны e.mongolia аппликейшн ашиглан 195 иргэнд лавлагаа мэдээллийг авах заавар зөвлөмжийг хүргэсэн.<br>Сэлэнгэ аймгийн Төрийн цахим үйлчилгээний хэлтсээс тавьсан хүсэлтийн дагуу Төрийн үйлчилгээний “Хурдан” цэгийн хаягжуулалтын ажлыг хийж гүйцэтгэн 300,000 төгрөгийг зарцууллаа. | 100 |
| 59 | “Таныг сонсъё” арга хэмжээг зохион байгуулна. | “Таныг сонсъё” арга хэмжээг малчид, тариаланчид, ногоочид, худалдаа үйлчилгээнийхэн, багийн хэсгийн дарга нар, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, бичил уурхай эрхлэгч, багийн иргэд гэсэн бүлгээр 9 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 771 иргэнд орон нутагт хийгдэж байгаа хөрөнгө оруулалтын ажил арга хэмжээ, мөн төрийн үйлчилгээний талаарх мэдээллийг танилцуулж, санал хүсэлтийг сонсож ажиллалаа. | 100 |
| 2.2 Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил, үйлчилгээ | | | |
| Хүн, нийгмийн амар тайван байдлыг бэхжүүлнэ. | | | |
| | Гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх | Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион | |

| | | | |
|---|---|---|---|
| 60 | , нийгмийн хэв журмыг сахиулах ажилд иргэдийн оролцоог нэмэгдүүлж, *“иргэд, олон нийттэй хамтарч ажиллана”*. | байгуулсан “Байгаль хамгаалагч”, “Нуугдмал”, “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй”, “Камержуулалт”, “Хүүхэд хамгаалал”, “Бод мал-Цацруулагч 2024”, “Уусан бол бүү жолоод”, “Цахим архи худалдаа”, “Тусгай зөвшөөрөл”, “Байгаль хамгаалагч-2024” зэрэг нэгдсэн болон тусгай арга хэмжээг хариуцсан сум, орон нутгийн хэмжээнд зохион байгуулан, эргүүл хяналт шалгалтаар 150 удаа давхардсан тоогоор 600 алба хаагч 1050 цагийн эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 167 зөрчлийг илрүүлэн 15.295.000 төгрөгний торгуулийн арга хэмжээ авч, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 20 зөрчил илрүүлэн ЗТХ-ийн 14.7 дугаар зүйлийн 3 дах хэсгийн 3.1 дэх хэсэгт заасан 1 жил эрх хасах 400 нэгжээр торгох арга хэмжээ авч шийдвэрлэсэн бол захиргааны журмаар 13 иргэнийг аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр оруулж 7-30 хоногийн хугацаатай баривчлуулах шийтгэл оногдуулсан байна. | 100 |
| 61 | Архидан согтуурахтай тэмцэх хяналт шалгалтын ажлын хүрээнд гудамж талбайн эргүүлийн ажлыг тогтмолжуулж, *“ Архигүй орчин”* хөтөлбөрийг хэрэгжүүлж, иргэдэд мэдлэг мэдээллийг олгож хамтарч ажиллана. | Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр 7 өрхтэй ажиллан СЭМҮТ-д 1 иргэнийг, аймгийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж, 1 иргэнийг холбон зуучилж, 6 иргэнд нөлөөлөн ажилласнаар 3 иргэн архины хамаарлаас гарч 3 иргэн ажиглалтад, 1 иргэн оршин суугаа байршлаа өөрчилсөн байна.<br>Архины хамааралтай 21 иргэнийг цагдаагийн байгууллагын судалгаа хяналтын санд шивж оруулсан. | 100 |
| 62 | Гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, зөрчлийг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор *“ Хамтарсан баг”*-ийн хяналтын үйл ажиллагааг дэмжиж хамтарч ажиллана. | Хүүхдийн эрхийг хангах, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан “Нуугдмал”, “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй”, “Хүүхэд хамгаалал” нэгдсэн арга хэмжээг хариуцсан сум орон нутагт хамтарсан багийн гишүүдийн хамтаар зохион байгуулсан.<br>Ерөө сумын ИТХ-ын 2023 оны 114 дүгээр тогтоолоор сумын төсвийн хөрөнгө оруулалтаар Түр хамгаалах өрөөний засварыг 10 сая, өрөөний тохижилтын ажилд 10 сая төгрөг, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас хамтарсан багийн үйл ажиллагааны зардалд 10 сая төгрөг тус тус төсөвлөгдөн батлагдсан ба хагас жилийн байдлаар уг зардлаас 7 төрлийн үйл ажиллагаанд 1.083.650 төгрөгийг зарцуулсан.<br>2024 оны хагас жилийн байдлаар Түр хамгаалах өрөөний засварыг “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГазар, тохижилтын ажлыг “Анагаагч зөгий” ХХК гүйцэтгэн 100 хувь хүлээлгэн өгсөн.<br>Гэр бүл рүү чиглэсэн “Хамтдаа”, “20 аав”, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” зэрэг сэдэвтэй 3 удаагийн сургалтад 326 иргэн хамрагдсан.<br>Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй айл өрх, эрсдэлт нөхцөлд амьдардаг 14 өрхийн 31 хүүхдийн судалгааг сум, тосгоны хамтарсан багийн гишүүдийн хамтаар гаргасан.<br>Гэр бүлийн хүчирхийлэл үйлдсэн 5 иргэнийг аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр оруулж 7-30 хоногийн хугацаатай баривчлуулах шийдвэр гаргуулж, дээрх иргэдийг цагдаагийн байгууллагын судалгаа хяналтын санд бүртгэсэн. | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| 63 | Хүүхдийг цахим гэмт хэрэг, мэдээллийн халдлага, ахуйн ослоос урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээг зохион байгуулж, энэ талын мэдлэг мэдээллийг эцэг, эх, хүүхдэд байнга өгч , хамтарч ажиллана. | Хүүхдийн эрхийг хангах, болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулсан “Нуугдмал”, “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй”, “Хүүхэд хамгаалал” нэгдсэн арга хэмжээг хариуцсан сум орон нутагт хамтарсан багийн гишүүдийн хамтаар зохион байгуулсан. Ерөө сумын ИТХ-ын 2023 оны 114 дүгээр тогтоолоор сумын төсвийн хөрөнгө оруулалтаар Түр хамгаалах өрөөний засварыг 10 сая, өрөөний тохижилтын ажилд 10 сая төгрөг, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зардлаас хамтарсан багийн үйл ажиллагааны зардалд 10 сая төгрөг тус тус төсөвлөгдөн батлагдсан ба хагас жилийн байдлаар уг зардлаас 7 төрлийн үйл ажиллагаанд 1.083.650 төгрөгийг зарцуулсан.<br>2024 оны хагас жилийн байдлаар Түр хамгаалах өрөөний засварыг “Төгөлдөр Ерөө” ОНӨААТҮГазар, тохижилтын ажлыг “Анагаагч зөгий” ХХК гүйцэтгэн 100 хувь хүлээлгэн өгсөн.<br>Гэр бүл рүү чиглэсэн “Хамтдаа”, “20аав”, “Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” зэрэг сэдэвтэй 3 удаагийн сургалтад 326 иргэн хамрагдсан.<br>Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэж болзошгүй айл өрх, эрсдэлт нөхцөлд амьдардаг 14 өрхийн 31 хүүхдийн судалгааг сум, тосгоны хамтарсан багийн гишүүдийн хамтаар гаргасан | 100 |
| 64 | Малын хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Малчдын бүлэг”-тэй хамтарч ажиллана. | Авто зам дагуу үйлдэгдэх мал, амьтнаас шалтгаалсан осол, гэмт хэргийн гаралтыг бууруулах, иргэдийн аюул, эрсдэлгүй авто замаар зорчих боломжийг бүрдүүлэх, зам тээврийн ослоос үүдэлтэй хүний амь нас, эрүүл мэнд, өмч, хөрөнгийг хамгаалах зорилгоор энэ оны 04 дүгээр сарын 12-ноос 05 дугаар сарын 01-ний өдрийн хооронд “Бод мал-Цацруулагч” нэгдсэн арга хэмжээг хариуцсан сумын хэмжээнд зохион байгуулсан. Арга хэмжээний хүрээнд сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 225.000 төгрөг шийдвэрлүүлж, төв зам дагуух 5 малчин айл өрхийн 120 орчим үхэр, морины хүзүүнд цацруулагч туузыг зүүж, зам тээврийн болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлж ажилласан.<br>Малчин айл өрхүүдээр явж мал хулгайлах гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх таслан зогсоох цагдаагийн байгууллагатай хэрхэн хамтарч ажиллах талаар болон хөдөө хээр малын бэлчээрт бага оврын ачааны тээврийн хэрэгсэл зүс танихгүй хүн явсан тохиолдолд боломжтой бол утсаар зургийг нь дарж баримтжуулан тэмдэглэн авч цагдаагийн байгууллагад мэдээлэл дамжуулан хамтран ажиллах мөн ойр хотны малчин айл өрхүүдийн малд алдуул мал ирж нийлсэн эсэх талаар асууж тодруулан сонор сэрэмжтэй байх талаар ухуулга яриа хийн санамж сэрэмжлүүлэг тараан ажилласан.<br>Алба хаагчдын гар дээр мал хулгайлах төрлийн 1, бусдын итгэмжит хариуцуулсан малыг дутааж хөрөнгө завшсан 1 хэрэгт мөрдөн шалгах ажиллагаа явуулж, мал хулгайлсан хэргийг хааж, хөрөнгө завшсан хэргийг эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж шийдвэрлэсэн.<br>Мал хулгайлах төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэн гаргасан нэвтрүүлэг, шторк, постерыг /Ерөө сумын нэгдсэн зар/, / Бугант тосгоны | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | нэгдсэн зар/ гэх тус сумын хандалт ихтэй цахим хаягуудаар дамжуулан иргэд, олон нийтэд сурталчлах ажлыг тухай бүр нь хийж гүйцэтгэн ажилласан | |
| 65 | Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хууль дүрмийг сурталчлах, хяналт шалгалтыг сайжруулах чиглэлээр төрөл бүрийн ажил арга хэмжээг зохион байгуулан нийтэд сурталчилж, *"замын тэмдэг тэмдэглэгээг шинэчилж сайжруулна"*. | Сэлэнгэ аймгийн цагдаагийн газраас согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодон осол аваар гаргах гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэсэн нөлөөллийн фото зураг, видео шторк зэргийг өөрийн болон тус сумын иргэдийн хандалт ихээр хийдэг цахим хаягуудад байршуулан ажилласан.<br><br>Ерөө сумын цагдаагийн тасгийн алба хаагч нарын хамт Сэлэнгэ аймгийн цагдаагийн газраас зохион байгуулсан нэгдсэн, хэсэгчилсэн болон нөлөөллийн арга хэмжээний хүрээнд идэвхтэй ажилласан.Ерөө сумаас 4 зам хүртэлх 37км замын хооронд үүссэн замын суулт, нүх гарсан хэсгийг тоолоход 30 тооны эвдрэл үүссэн байсныг Фото зургаар баримтжуулан замын осол аваар гарах учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажил, арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр эрх бүхий албан хаагчаар тус сумын удирдлагуудад 2 удаа албан шаардлага хүргүүлсэн.<br>Сэлэнгэ аймгийн цагдаагийн газрын Ерөө сумын цагдаагийн тасгийн алба хаагчид "Бод мал-цацруулагч" 2024 нэгдсэн арга хэмжээний хүрээнд хариуцсан сум орон нутагт буюу Ерөө сум, Бугант тосгонд дараах ажлыг хийж гүйцэтгэн ажилласан.<br>Арга хэмжээний хүрээнд шаардлагатай бод малын цацруулагч хүчүүвж авах зардал төсвийн судалгааг гаргаж сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлд танилцуулан 225.000 мянган төгрөг шийдүүлэн ажилласан. Тус сумын бод мал зам хөндлөн гардаг болон асфальтан зам дагуу малчин айл өрхүүдийн өрхүүдийн судалгааг гаргаж 11 малчин мал бүхий айл өрхөөр явж 150 орчим "бод малд" цацруулагч хүзүүвч хийн учирч болох эрсдэл зам тээврийн осол аваараас урьдчилан сэргийлэх ажил зохион байгуулан ажилласан | 100 |
| 66 | Байгаль орчны гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжийг зөрчсөн иргэн, ААНэгжийн үйл ажиллагааг таслан зогсоож, хяналтыг сайжруулна. | Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр тус цагдаагийн тасгийн алба хаагчид болон Экологийн цагдаагийн алба, Сэлэнгэ аймгийн цагдаагийн газар, сум, тосгоны байгаль орчны хяналтын улсын байцаагч нарын хамтаар 18 удаагийн 144 цагийн хяналт шалгалтыг зохион байгуулсан. Хяналт шалгалтаар хууль бусаар ашигт малтмал олборлосон 16, хууль бусаар мод бэлтгэсэн 7 гэмт хэргийн шинжтэй үйлдлийг илрүүлэн мөрдөн шалгах ажиллагаа явуулж байна. Дээрх гэмт хэргийг үйлдэхэд ашигласан техник хэрэгсэл болон энэ төрлийн гэмт хэрэг үйлдэхээр техник хэрэгслээ ууланд нуусан байсан 25 техник хэрэгслийг төв рүү татаж, нэгдсэн журмаар парклан, лацадсан.Экологийн цагдаагийн албаны урьдчилан сэргийлэх хамтын ажиллагааны хэлтсийн 2 ахлах мэргэжилтэн, Монголын бичил уурхайн нэгдсэн дээвэр холбоо, "Ди Эс майнд инвестмент консалтинг" хуулийн зөвлөх үйлчилгээний холбогдох албан тушаалтнууд энэ оны 03 дугаар сарын 28-ны өдөр ирж Бугант тосгоны 170 иргэнд "Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргийн тухай ойлголт, "Мөнгөн усны хор аюул", "Бичил уурхай" зэрэг сэдвээр сургалт зохион байгуулсан.<br>Ерөө сумын 3 дугаар баг Бугант тосгоны нутаг "Толгойтын даваа" хяналтын постод | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдын ажиллах орчныг сайжруулах, тэдний амь нас, эрүүл мэндийг хамгаалах, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор явуулын чингэлэг шийдвэрлэж өгөх талаар өнгөрсөн оны 12 дугаар сард аймгийн онцгой комисст танилцуулж, 19 сая төгрөг шийдвэрлүүлсэн. Аймгийн онцгой комиссын санхүүжилтээр Ерөө сумын иргэнээр явуулын чингэлэг хийлгэж, дуусган энэ оны 06 дугаар сард “Толгойтын даваа” хяналтын постод байрлуулж, алба хаагчдад хүлээлгэн өгсөн. | |
| 3.ЭДИЙН ЗАСАГ, САНХҮҮГИЙН БОДЛОГО | | | |
| Тогтвортой эдийн засаг хөгжлийн тулгуур | | | |
| 3.1 Хөдөө аж ахуйн бодлого | | | |
| Газар тариалан, эрчимжсэн мал аж ахуй, үйлдвэрлэлийн салбарыг хөгжүүлнэ. | | | |
| 67 | Өвөл, зуны хүлэмжийн аж ахуй эрхлэгчдийн тоог нэмэгдүүлж сумын иргэдийг хүнсний ногоогоор хангаж, бүх төрлийн хүнсний ногооны суулгац, үрсэлгээгээр орон нутгийн иргэдийг хангах бодлогыг хэрэгжүүлж ажиллана. | 2024 оны 05 дугаар сарын 17 нд Ерөө суманд Ургац Ерөө хоршооны ногоочид өөрсдийн бэлтгэсэн 30 гаруй төрлийн хүнсний ногоо, мандалын цэцэгний үрсэлгээний үзэсгэлэн худалдааг зохион байгууллаа. Мөн Хүдэр , Дархан-уул аймгийн зах худалдааны төвүүдээр худалдаалан нийт 2 сая орчим төгрөгийн борлуулалт хийсэн байна.<br>500 м2 өвлийн хүлэмжинд Адра олон улсын байгууллагын Органик хөдөө аж ахуйн түншлэл төслийн хүрээнд хүнсний нийлүүлэлт борлуулалтын үр ашигтай сүлжээг талуудын оролцоотойгоор бий болгох зорилгоор төсөлд хамрагдсан Ургац Ерөө хоршоотой хамтран Японы шилмэл сортын /жимсгүхэ / улаан лоолийг үрсэлгээг нийлүүлэн тариалалт хийж нийт 5 удаагийн хураалтаар 733,3 кг лооль хураан авч 11,000,000 төгрөгийн борлуулалтыг хийсэн байна.<br>Өрхийн хэрэгцээнд 61 өрх, 6 хоршоо нийт 3516 м2 хүлэмжинд өргөст хэмх, лооль , чинжүү, навчит ногоо тариалан нийт 30 тн ургац хураан авсан байна. | 100 |
| 68 | Төмс, хүнсний ногоо тариалж буй иргэдийн ногоог хадгалах зорилгоор стандартын шаардлага хангасан 100 тонны багтаамжтай зоорийг байнгын ажиллагаатай болгож Бугант тосгонд 100 тонны зоорь барих ажлыг эхлүүлнэ. | 2024 оны 03 дугаар сарын 13 нд Аймгийн хүнс хөдөө аж ахуйн газраас ажлын хэсэг ирж 100 тн зоорьны ашиглалттай танилцсан бөгөөд цаашид зоорийг 100 хувь бүрэн ашиглах тал дээр анхаарч ажиллахыг зөвлөлөө. Энэ онд Ургац ерөө хоршооны гишүүдийн 65 тн төмсийг хадгалаад байна. | 80 |
| 69 | Бэлчээрийн ургамлын бүтцийг сайжруулах чиглэлээр олон наст ургамал *”ногоон тэжээл”* тариалах иргэн, малчид, хоршоог бодлогоор дэмжиж ажиллана. | Энэ онд үр тарианы 2 ААН, 2 иргэн 165,2 га талбайд тэжээлийн ургамал тариалж 137 тн ургац, 56,1 га талбайд Овьёос тариалан 106 цн ургац тус тус хураан авсан байна. Энэ нь өмнөх онтой харьцуулахад тэжээлийн ургамал тариалалт 90,2 га талбайгаар нэмэгдсэн үзүүлэлттэй байна.<br>Мөн Монгол улсын засгийн газрын 166 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган Шинэ хоршоо хөдөлгөөнийг хүрээнд малчдын хоршоо байгуулагдан дотооддоо ногоон тэжээл тариалах газар олгох хүсэлтээ гаргасан байна. | 80 |
| | | 2024-2025 оны өвөлжилт, хаваржилтийн хүрээнд биенесийн зориулалтаар хадлан бэлтгэж буй иргэдийн гэрээний дагуу 4000 боодол буюу 80 тн өвсийг нөөцлөж, | |

| | | | |
|---|---|---|---|
| 70 | Сумын өвс , тэжээлийн фонд бүрдүүлэх арга хэмжээг авч САРАВЧ, БАЙР-тай болох ажлыг хэрэгжүүлнэ. | шаардлагатай үед 40 тн тэжээл худалдан авахаар төсөвт тусгасан.111,2 сая төгрөгийн санхүүжилтээр “Би эс би ая”ХХК нөөцийн , өвсний фондны саравчийг 100% гүйцэтгэсэн. | 100 |
| 71 | *“Алтан намар”, “Сэлэнгэд үйлдвэрлэв” , “ Намрын ногоон өдрүүд”* зэрэг уламжлал болгон зохион байгуулагддаг аймаг, улсын үзэсгэлэн худалдаанд ногоочид болон жижиг дунд үйлдвэрлэл, өрхийн үйлдвэрлэл эрхлэгчдийг оролцуулж, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах замаар харилцан туршлага солилцуулах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллана. | Сэлэнгэ аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газраас зохион байгуулсан “Цагаан сар-2024” үзэсгэлэн худалдаанд сумаас 4 иргэн цагаан идээ, дарсан ногоо, жимс жимсгэнэ, модон эдлэл, дээл, хантааз зэрэг 28 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 2,660,000 төгрөгийн борлуулалт хийсэн байна.<br>“Ерөөлтэй цагаан сар-2024” үзэсгэлэн худалдаа сумын Соёлын төвд зохион байгуулагдаж Үзэсгэлэн худалдаанд 2 хоршоо 15 иргэн, жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч 52 төрлийн бараа бүтээгдэхүүнээр оролцож 7,840,000 төгрөгийн борлуулалт хийсэн.<br>ХХААХҮЯам болон Сэлэнгэ аймгаас зохион байгуулсан “АЛТАН НАМАР-2024” арга хэмжээнд 3 хоршооны 11 иргэн даршилсан ногоо болон нарийн ногоо, цөцгий, ааруул зэргийн бүтээгдэхүүнээр оролцож нийт 7.500.000 төгрөгний худалдан борлуулалт хийсэн. Мөн төрийн банкнаас зохион байгуулсан хамгийн олон бүтээгдэхүүнтэй оролцогч номинацид 1-р багийн ногоочин Г. Сувдмаа шалгарсан. | 100 |
| 72 | Мал эмнэлгийн үйл ажиллагаанд төрөөс тавих хяналтыг сайжруулан урьдчилан сэргийлэх арга хэмжээг чанаржуулж "*Эрүүл малтай"* сум болно. | Улсын санхүүжилттэй тарилга (боом, галзуу, гахай мялзан)-д 22700 толгой мал 1500 толгой амьтан нийт 24200 толгой мал амьтан, Орон нутгийн санхүүжилттэй тарилга (дуут хавдар, цусан халдварт, дотрын халдварт хордлого, шөвөг яр, сахуу, гахайн цусан халдварт иж балнад)-д 36600 толгой мал, 680 толгой амьтан, нийт 37280 толгой мал, амьтан 9 төрлийн тарилгыг 61480 толгой мал, амьтан дархлаажуулалтад хамрагдсан. Угаалгад 70907 толгой мал, амьтан, туулгалтад 79300 толгой мал, амьтан, боловсруулалтад 70370 толгой мал, амьтан нийт сумын хэмжээнд давхардсан тоогоор 220577 толгой мал амьтан шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамрагдлаа. “Таван Эрдэнэ вэт” мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн эмч Г.Болд-Эрдэнэ, Мал эмнэлгийн Улсын байцаагч А.Анхбаяр болон 1,2,3-р багийн 10 иргэн нийт 12 хүний бүрэлдэхүүнтэйгээр 510 гаруй мал амьтны сэг зэмийг устган 1400м2 талбайд ариутгал халдваргүйтгэл хийж ажиллалаа. Мөн мал, амьтны хашаа хороо, хэвтэр бууцанд ариутгал халдваргүйтгэлийг Лхачимбу мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн захирал, малын эмч С.Эрдэнэбат 260000м2, Таван эрдэнэ вэт мал эмнэлгийн үйлчилгээний нэгж 133100м2 нийт 407100 м2 квадрат талбайд ариутгал хийгдсэн байна. Гарал үүслийн нийт 1126 гэрчилгээ бичигдсэн. • Амьдаар 435 гэрчилгээ: гарч Адуу-177, Үхэр-681, Хонь-1450, Ямаа-1243, Гахай-35 толгой мал амьтан • Бүтээгдэхүүний зорилгоор-358 гэрчилгээ гарч Үхрийн мах-274тн689кг, Адууны мах-5475кг, Гахайн мах-455кг, Хонины мах-8167кг, Ямааны мах-2395кг нийт 291181кг мал амьтны мах бичигдсэн байна. • Дайвар бүтээгдэхүүн Адууны арьс-10ш, толгой-68 ш, Үхрийн арьс-150ш, Сүү-4720л, толгой-68ширхэг, Цувдаа-2600, шийр-40ш, Ямааны арьс 100ш ноос 2000кг тус тус худалдан борлуулсан байна. • Отор нүүдлээр 45 гэрчилгээ: Адуу-138, Үхэр-187, Хонь-118, Ямаа-84, толгой мал • Үржилд :288 гэрчилгээ Адуу-413, Үхэр-546, Хонь-189, Ямаа-257, Толгой мал | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | 2024 оны хаврын мал эрүүл мэндийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд<br>• Боомын вакцин 3000 үхэр, 1000 хонь<br>• Дуут хавдрын вакцин 1200 үхэр<br>• Цусан хавдар 800 үхэр<br>• Мялзангийн вакцин 100 гахайд хийгдсэн.<br>Сэлэнгэ аймгийн Ерөө сумын 2024 оны 08 сарын 13- ны өрийн А\183 тоот захирамжийн хүрээнд бруцеллёз өвчний вакцинжуулалтад тосгоны хэмжээнд Баянгол, Ходоодын чиглэлд 1600хурга ,765 тугалд хийгдсэн | |
| 73 | Бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор алсын бэлчээрт *” худаг ус гаргах”,* зам давааг засан сайжруулах арга хэмжээг дэс дараатай хэрэгжүүлнэ. | Бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор малын тоо толгойн албан татварын хөрөнгөөр 3 хэсэгт гүний цооног гаргахаар 40 сая төгрөгийн санхүүжилт тавьж орон нутаг хөгжлийн сангаар тендер зарлан “Гранд холдинг” ХХК шалгарч гэрээ байгуулаад худгаа гарган хүлээлгэн өгөөд байна. | 100 |
| 74 | Малчид, тариаланчдын зөвлөгөөнийг зохион байгуулна. | 2024 оны 04 дүгээр сарын 18 нд Төв аймагт төвийн бүсийн тариаланчдын уулзалтыг зохион байгууллаа. Энэхүү уулзалтанд 4 чиглэлээр буюу үр тарианы 5 ААН, Жимс жимсгэнэ мод үржүүлэгч 1 ААН, Хүнсний ногоо тариалагч 2 иргэн, төмс тариалагч 1 ААН тус тус оролцлоо.<br>2024 оны 06 дугаар сарын 27 нд Сэлэнгэ амигийн ХХААГ, Япон улсын Шизоука мужийн хамтын харилцааны хүрээнд Ерөө сумын ногоочдод хүнсний ногооны ил талбайн тариалалт туршлага судлах, зөвлөгөө хүргэх уулзалтыг зохион байгууллаа. Уулзалтанд 1,2-р багийн нийт 20 ногоочин хамрагдлаа.<br>Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “ШИНЭ ХОРШОО-ЧИНЭЭЛЭГ МАЛЧИН” аяны хүрээнд сумынхаа 1,2,3-р багийн 220 гаруй малчин, мал бүхий иргэдэд эрчимсэн мал аж ахуйн эрхлэх, малын үүлдэр угсааг сайжруулах талаар мэдээлэл өгөгдсөн. Хөдөө малчдаар тойрч өвөлжилт, хаваржтлийн талаар танилцаж санал хүсэлтийг нь сонсож цаг үеийн мэдээ, мэдээллээр хангаж ажилласан бөгөөд салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар байнга сурталчилж байна. | 100 |
| 75 | Бэлчээр, хадлангийн менежмент төлөвлөгөөг боловсруулан хянан баталгаар хийлгэж, талбайн ашиглалтыг сайжруулна. | НҮБ-ийн стрийм төслийн санхүүжилтээр хийгдсэн нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд бэлчээрийн газраас ашиглах 103939,7 га талбайг зун намар, өвөл хаврын бэлчээрийн хилд хуваан төлөвлөсөн.<br>Үүний хүрээнд:<br>• 1-р багт зун намрын бэлчээр 5977 га, өвөл хаврын бэлчээр 47348 га,<br>• 2-р багт 727 га зун намрын бэлчээр, өвөл хаврын бэлчээр 43205 га<br>• Бугант тосгонд 892 га зун намрын бэлчээр, өвөл хаврын бэлчээр 5791 га<br>Мөн нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөнд 11825,9 га талбайд хадлангийн | 70 |

| | | | |
|---|---|---|---|
| | | газрын төлөвлөлтийг тусгасан байна. Хадлангийн талбайн ашиглалтыг сайжруулах зорилгоор энэ онд сумын хэмжээнд 350 малчин ,мал бүхий өрх, бизнесийн зориулалтаар 49 иргэн нийт 5166 га талбайд хадлангийн гэрээ байгуулан 15500 тн өвс тэжээл бэлтгэсэн байна. Талбайн ашиглалт 43,6 хувьтай байна.. | |
| 76 | Хүнсний хангамж аюулгүй байдлыг хангах хөтөлбөрийн хүрээнд ХУВАНЦАР САВНААС ТАТГАЛЗЪЯ АЯН-ыг өрнүүлэх | Сумын хэмжээнд “Ерөөлтэй цагаан сар-2024” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж Хөх сав, канистергүй сум болох зорилгоор Дархан-уул аймгийн хөнгөн цагаан сав суулга зардаг иргэдийг урьж оролцуулсан. Мөн Засаг даргын Тамгын газрын вэб сайтад мэдээлэл нийтэлж 50 гаруй иргэнд сургалт мэдээлэл өгч ажилласан. | 70 |
| 77 | Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнүүдэд *“ШИНЖИЛГЭЭ ХИЙХ ЛАБОРАТОРИ”*-ийг мал эмнэлэг үйлчилгээний нэгжийг түшиглэн байгуулж, шаардлагатай техник хэрэгслээр хангах замаар үйл ажиллагааг нь тогтмолжуулна. | | 0 |
| 78 | Үр тариа болон төмс, хүнсний ногоон ХӨРСНИЙ ШИЛЖИЛГЭЭГ хийлгэх | 2024 онд үр тарианы 4 ААН тариалангийн талбайн хянан баталгааг хийлгэсэн байна. | 100 |
| 3.2 Үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээний бодлого | | | |
| Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй, үйлдвэрлэл эрхлэлтийг дэмжинэ. | | | |
| 79 | Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгийн эх үүсвэрийг нэмэгдүүлж иргэдийнхээ жижиг дунд үйлдвэрлэл эрхлэх үйл ажиллагааг дэмжинэ. | Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд орчин үеийн санхүүжилтийн хэлбэрүүдийг нэвтрүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газраас зохион байгуулсан “Бэст” хөтөлбөртэй хамтран Хоршоо хөгжүүлэх сангийн журам, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрт хэрхэн хамрагдах, зээлийн батлан даалтын сан, гарааны бизнес дэмжих, хас банкны хөнгөлөлттэй зээл төсөл бичихэд анхаарах асуудлын талаарх 4 удаагийн сургалтад давхардсан тоогоор сумын 56 иргэд, жижиг дунд бизнес эрхлэгч, хоршоодыг хамруулж үйл ажиллагааг дэмжин ажилласан. Хас банкны эмэгтэй бизнес эрхлэгчдэд барьцаагүй зээл олгох хөтөлбөрт Ерөө сумаас 1 иргэн, Жижиг дунд бизнес эрхлэгчээр 1 иргэн Бэст хөтөлбөрийн гарааны бизнес хөтөлбөрт 1 хоршоо хамрагдсан. | 100 |
| 80 | Худалдаа үйлчилгээний салбарын үйлчилгээний чанар, боловсон хүчний чадавхийг сайжруулж үйлчилгээний соёл, стандарт мэдлэг мэдээллийг дээшлүүлэх сургалтанд хамруулж ур чадвар, соёлыг дээшлүүлнэ”. | Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих,архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25,1 дэх заалт согтууруулах ундаагаар үйлчлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн бусдад үйлчлэх үүрэг бүхий ажилтан нь согтууруулах ундааны “Хариуцлагатай үйлчилгээний сургалт”-д хамрагдсан байна гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар “Сэлэнгэ нутгийн залуус” ТББ-тай хамтран “Хариуцлагатай үйлчилгээний сургалтыг суманд 2024 оны 04 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгууллаа. Тус сургалтад сумын 26 аж ахуйн нэгжийн төлөөлөл 29 иргэн оролцож Гэрчилгээ олгох шалгалтад хамрагдав. Сумандаа “ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ” сэдэвт арга хэмжээний нээлтийг зохион байгуулж худалдаа үйлчилгээ эрхлэгч 21 иргэн оролцлоо. “Салбарын чиглэлээр хэрэгжиж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, стандарт”, “Хүнс болон жижиг дунд үйлдвэрлэлийн салбарт авч хэрэгжүүлэх ажлууд талаар, сумын түүхт 100 жилийн | 100 |

| | | | |
|---|---|---|---|
| | | ойг угтсан тохижилтын ажил эрчимжүүлэх, тамхины худалдаа үйлчилгээ эрхлэгчдэд зөвлөмж танилцуулан тараах материалаар аж ахуйн нэгж дэлгүүр, хоол үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчдэд өгсөн. Мөн бугант тосгоны томоохон дэлгүүрүүдээр явж хяналт шалгалт хийн цаашид анхаарч ажил тал дээр зөвлөгөө, зааварчилгаа өгч ажилласан. | |
